“КЕАРО” ХХК-НИЙ “СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМААС БИЧИГТ БООМТЫН ТӨВ ЗАМ ХҮРТЭЛХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ” ЗУРАГ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



Тайлан захиалсан:
“Каеро” ХХК-ний захирал Р.БУД

Тайлан боловсруулсан:
“Тэкол” ХХК-ний захирал Т.МӨНХЖАРГАЛ

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА. 5
1.1. Төслийн талаарх мэдээлэл: 5
1.2. Төслийн танилцуулга 5
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ 11
2.1. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр: 11
2.2. Алслалт, зам харилцаа 11
2.3. Газрын гадарга, ландшафт 12
2.4. Газрын гадаргын налуу 13
БҮЛЭГ 3. УУР АМЬСГАЛ. 15
3.1. Уур амьсгал 15
3.2.Хур тунадас 16
3.3.Агаарын температур 17
3.4. Салхи, салхины чиглэл 20
БҮЛЭГ 4. АГААРЫН ЧАНАР. 22
4.1. Танилцуулга 22
4.2. Судалгааны арга зүй 22
4.3. Судалгааны үр дүн 22
4.4. Дүгнэлт, зөвлөмж 23
БҮЛЭГ 5. ФИЗИК БОХИРДОЛ 24
5.1. Танилцуулга 24
5.2. Судалгааны арга зүй 24
5.3. Судалгааны үр дүн 24
БҮЛЭГ 6. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ БА ГЕОМОРФОЛОГИ 25
6.1. Геологийн тогтоц 25
БҮЛЭГ 7. ГАДАРГЫН УС 28
7.1 Гадаргын ус 28
БҮЛЭГ 8. ГАЗРЫН ДООРХ УС 31
8.1. Судлагдсан байдал 31
БҮЛЭГ 9. ХӨРСӨН БҮРХЭВЧ 36
9.1. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч 36
БҮЛЭГ 10. УРГАМЛАН НӨМРӨГ 43
10.1. Ургамлан нөмрөгийн байдал 43
10.2. Ургамлан нөмрөгийн өнөөгийн байдал 50
БҮЛЭГ 11. АМЬТНЫ АЙМАГ 53
11.1. Амьтны аймаг 53
БҮЛЭГ 12. ТҮҮХ СОЁЛЫН ӨВ 55
13.1. Хүн амын тоо ба өрхийн байдал 61
БҮЛЭГ 14. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛҮҮД 65
14.1. Үүсэж болзошгүй нөлөөлөл, аюулууд 65
14.2. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт, хэрэгжилттэй холбогдсон болзошгүй нөлөөлөл 66
14.3. Байгаль орчин, нийгэмд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх 68
14.3.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах 68

14.3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах 69
14.3.3 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах 70
БҮЛЭГ 15. АШИГЛАСАН МАТЕРИАЛ ЭХ СУРВАЛЖ 71

УРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Авто замын трасс 6
Зураг 3. Төслийн байршил 11
Зураг 4. Төслийн талбай хүрэх шороон замын зураг 12
Зураг 5. Сумын байршлын схем 12
Зураг 6. Асгат сумын байршлын схем 13
Зураг 7. Дарьганга сумын агаарын температурын олон жилийн дундаж 17
Зураг 8. Дарьганга сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм 18
Зураг 9. Асгат сумын агаарын температурын олон жилийн дундаж 19
Зураг 10. Асгат сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм 20
Зураг 11. Баяндэлгэр өртөө, салхины дундаж хурд м/с 2016-2020 оны дунджаар 20
Зураг 12. Тоосонцрын хэмжилтийн багаж DustTrak T SI 85 22
Зураг 13. Хэмжилт хийсэн байршлууд 23
Зураг 14. Дуу шуугиан хэмжигч багаж 24
Зураг 15. Сумын инженер геологийн нөхцөл 26
Зураг 16. Асгат сумын төвийн инженер геологийн нөхцөл 27
Зураг 17. Геоморфологийн дэвсгэр зураг 27
Зураг 18. Гадаргын усны зураг 28
Зураг 19.Гадаргын усны зураг 30
Зураг 20. Газрын доорх ус 35
Зураг 21. Хөрсний хэв шинж 42
Зураг 22. Дарьганга сумын ургамлын экологийн хэв шинж, эзлэх хувиар 43
Зураг 23. Төслийн талбай дахь ургамал 51
Зураг 24. Ургамалын бичиглэл 51
Зураг 25. Ургамлан нөмрөг 52
Зураг 26. Амьтны тархалтын нөөцийн зураг 53
Зураг 27. Алтан-Овоо 56
Зураг 28. Ноён, Хатан, Хүү, Бэрийн чулуу 56

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Физик газарзүйн хувьд үзүүлэх сөрөг нөлөөлөл 14
Хүснэгт 2. Хур тунадасны нийлбэр, мм 16
Хүснэгт 3. Хур тунадас, Баяндэлгэр өртөө, мм, 2020-2024 он 17
Хүснэгт 4. Дарьганга сумын агаарын температурын олон жилийн дундаж статистик үзүүлэлтүүд 17
Хүснэгт 5. Асгат сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм, 1991-2024 он 18
Хүснэгт 6. Асгат сумын агаарын температурын олон жилийн дундаж статистик үзүүлэлтүүд 19
Хүснэгт 7. Асгат сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм, 1991-2024 он 19
Хүснэгт 8. Баяндэлгэр өртөө, Салхины дундаж хурд м/с /2020-2024/ 20
Хүснэгт 9. Баяндэлгэр өртөө, Салхины дундаж хурд м/с /2020-2024/ 21
Хүснэгт 10. Төслийн талбайн агаар дахь PM 10 болон PM 2.5 тоосонцрын агууламж, мг/м3 22
Хүснэгт 11. Төслийн талбайд хийгдсэн дуу шуугианы хэмжилтийн үр дүн 24
Хүснэгт 12. Усны сав газрын үзүүлэлт 28
Хүснэгт 13. Усны сав газрын үзүүлэлт 29
Хүснэгт 14. Газрын доорх усны нөөц баялгийн нөхцөлийн шалгуур 32
Хүснэгт 15. Асгат сумын гидрогеологийн нөхцөл 32
Хүснэгт 16. Газрын доорх усны нөөц баялгийн нөхцөлийн шалгуур 34
Хүснэгт 17. Хөрсний морфологи бичиглэл 1 38
Хүснэгт 18. Хөрсний морфологи бичиглэл 2 39
Хүснэгт 19. Хөрсний морфологи бичиглэл 3 39
Хүснэгт 20. Хөрсний морфологи бичиглэл 4 40
Хүснэгт 21. Хөрсний морфологи бичиглэл 5 40
Хүснэгт 22. Хөрсний агрохимийн шинж чанар 41
Хүснэгт 23. Хөрсний механик бүрэлдэхүүн 41
Хүснэгт 24. Сумын ургамлын экологийн хэв шинж 43
Хүснэгт 25. Дорнод Монголын цав толгодорхог нам уулс бүхий хээрийн мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн 54
Хүснэгт 26. Түүх соёлын дурсгалт газрын байршил 55
Хүснэгт 27. Нөлөөллийн үнэлгээ 65
Хүснэгт 28. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт 67
Хүснэгт 29. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийг ангилах нь 68
Хүснэгт 30. Хамгаалах бүс 69

ОРШИЛ.

"Кеаро" ХХКомпанийн Сүхбаатар аймгийн Дарьганга, Асгат сумдын нутагт орших "Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам" зураг төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг "Кеаро" ХХКомпанитай байгуулсан гэрээний дагуу "Тэкол" ХХКомпани боловсруулав.

Тухайн ажлыг гүйцэтгэхдээ хоёр талын байгуулсан гэрээг удирдлага болгон ажилласны зэрэгцээ Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн А-117 дүгээр тушаалаар батлагдсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал"– ын 1-р хэсэг Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх аргачлалын дагуу хийсэн болно.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилт нь аливаа төсөл, хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах эхний шатанд тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал тухайлбал, газарзүйн нөхцөл, геологийн тогтоц, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, мөн түүнчлэн нутгийн иргэд, оршин суугчид, тэдний нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эрүүл мэнд, түүх соёлын өвийн өнөөгийн төлөв байдлыг тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачид, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор, шинжлэх ухааны судалгааны аргазүйг ашиглан тодорхойлоход бүрэн чиглэгдэх юм.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлыг хээрийн болон суурин боловсруулалтын үе шаттайгаар хийж, уг ажилд өөрийн компани холбогдох экспертүүдийг оролцуулан төслийн байрлах орчмын суурь үнэлгээг газар дээр нь гүйцэтгэж, суурин боловсруулалтын ажилд ArcGIS 10.4.1, Google Earth, ENVI 4.7, Surfer 16.0, SaS Planet зэрэг программуудыг ашиглаж үнэлгээний тайланг боловсруулав.

БҮЛЭГ 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.

1.1. Төслийн талаарх мэдээлэл:

Төслийн нэр:	"Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам" зураг төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	"Кеаро" ХХК
Регистрийн дугаар:	5086833
Утас:	976- 99116241, 976-99903047
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Соёмбо тауэр, 191 тоот
Төслийн зорилго:	Дарьганга сумын төвөөс Бичигт хилийн боомттой холбох авто замын энэхүү чиглэл нь олон улсын болон орон нутгийн тээврийг оновчтой зохион байгуулах, ачаа болон зорчигч эргэлтийг нэмэгдүүлэх, хөрсний элэгдлийг бууруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой.
Төслийн байршил:	Сүхбаатар аймаг, Дарьганга, Асгат сумдын нутагт хэрэгжинэ.

1.2. Төслийн танилцуулга

МУЗГазрын 2025 оны 02 дугаар сарын 19 -ний өдрийн 97 дугаар тогтоол, Монгол Улсын шадар сайдын 2025 оны 03 дугаар сарын 28 -ны өдрийн А/50 дугаар тушаал. 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ТЭЗҮ-09/25 дугаар техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврын дагуу боловсруулагдсан ТЭЗҮ-д тусгагдсан (Зам, тээврийн яамны дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр дэмжигдсэн) авто замын трассын дагуух нутаг дэвсгэр хамаарна

Төлөвлөлтийн норм:

- "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016
- "Хот суурины гудамж зам төлөвлөлт" БНбД 32-01-04
- "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН 2.01.01-2004
- "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНбД 22.01.0172006
- "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11- 07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНбД 3.01.03-88
- "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS4597:2014
- "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэхдүрэм" MNS4596:2014
- "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/ барилгын дүрэм
- "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009
- Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598: 2020

- Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц MNS6515:2015
- Ууархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц Ерөнхий шаардлага MNS6735:2018
- Бусад шаардлагатай Монгол улсын холбогдох ЗЗБНбД, БНбД болон стандартуудыг хатуу баримтлан, тэдгээрт бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ.



Зураг 1. Авто замын трасс

Зураг 2. Авто замын трассын дагуух өнөөгийн байдал

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

2.1. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр:

Сүхбаатар аймаг, Дарьганга, Асгат сумдын нутаг дэвсгэрт хэрэгжинэ. Улаанбаатар хотоос 728 км зайтай. Сүхбаатар аймгийн төвөөс 128 км зайтай.



Зураг 3. Төслийн байршил

2.2. Алслалт, зам харилцаа

Улаанбаатар хотын төс цэгээс зүүн тийш 728 км зайтай, Сүхбаатар аймгийн төв хүртэл улсын хатуу хучилттай авто замаар явж хүрнэ. Сүхбаатар аймгийн төвөөс Урагш 128 км хатуу хучилттай авто замаар явж төслийн талбайд хүрнэ.

Зураг 4. Төслийн талбай хүрэх шороон замын зураг

2.3. Газрын гадарга, ландшафт

Дарьганга сум:

Дарьганга сум нь Асгат сумтай 84.24 км, Эрдэнэцагаан сумтай 51.04 км, БНХАУ-тай 66.6 км, Наран сумтай 85,01 км, Онгон сумтай 19,9 км газраар тус тус хиллэн оршдог. Тус сумын хамгийн өндөр цэг далайн түвшнээс дээш 1777.5 м өргөгдсөн Шилийн богд уул бөгөөд Монгол орны физик газар зүйн мужлалаар Монголын Дорнод талын их мужийн Дарьгангын талархаг нутагт хамаарна.

Дарьганга сумын нийт нутаг дэвсгэрийн 74.8 хувийг тал хээрийн бэлчээрийн ургамал, 9.8 дундаж өндөр ба нам бэсрэг уул ургамлын бэлчээр, 7.1 хувийг говь цөлийн бэлчээрийн ургамал 5.9 хувийг бүс дундын голын хөндийн, нам хотосын бэлчээрийн ургамал тархсан байдаг. Энд ухаа гүвээ, нугачаа тал ихээхэн талбайг эзлэхийн зэрэгцээгээр эртний галт уул болон бусад уул нэлээн байна. Ухаа гүвээгүй, тэгшивтэр тал ч бас бий. Мөн элс багагүй тархана. Сум нутаг дэвсгэрийн үнэмлэхүй өндөр нь 1150-1700 метр хүрнэ.



Зураг 5. Сумын байршлын схем

Галт уулын гаралтай гадарга 380580.68 га, Тэгширмэл газар, уулс хоорондын ба уулан дундах хотгор, голын хөндий дэх хурмал хурдас 28842.33 га, Тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь элэгдлийн гаралтай 37102.10 га байна.

Асгат сум:

Тус сум нь физик газар зүйн мужлалаар Монголын дорнод талын их мужид хамаарах ба Дарьгангын ухаа гүвээт талархаг газрын дэд мужид хамрагдана. Энэ дэд муж нь

дунджаар далайн түвшнээс дээш 1000м өргөгдсөн ба тэгш талбай ихтэй. геологийн тогтцын хувьд дунд төрмөлийн ба гуравдагч галавын хурдас зонхилно. Сумын зүүн өмнөд хэсэг нь галт уулын нөлөөгөөр үүсэж тогтсон бөгөөд тэдгээрийн дүрс хэлбэр жинхэнэ галт уулынхтай ойролцоо эгц огцом хажуутай, оройд нь өрх маягийн ул мөр хадгалагдан үлдсэн байдаг ба 1200м-ээс дээш өргөгдсөн намхан уулс нэлээд олон тохиолдоно. Тэгш ухаа гүвээт талуудын хооронд багахан хэмжээний хотос хонхрууд нэлээд хэмжээгээр байх бөгөөд тэдгээрт багахан хэмжээний давст нуурууд тогтсон байдаг. Сумын төв нь аймгийн төвөөсөө 48 км зайд, Улаанбаатар хотоос 598 км-т байрлана. Асгат сум нь Халзан, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдтай хиллэн оршино. Асгат сум нь нийт 720863.16 га газар нутаг дэвсгэрийг хамарна.



Зураг 6. Асгат сумын байршлын схем

Галт уулын гаралтай гадарга 185445.97 га, Тэгширмэл газар, уулс хоорондын ба уулан дундах хотгор, голын хөндий дэх хурмал хурдас 79905.51га, Тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь элэгдлийн гаралтай 455511.67га байна.

2.4. Газрын гадаргын налуу

Судалгааны талбайд ажиллаж байхад улсын чанартай авто замын баригдаж байгаа төслийн хажуу талд шинээр зураг төсөл хийгдэж байгаа юм. Зургийн түвшинд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдэж байна. Барилгын ажлын үед хөрс хуулагдах үүсэх эрсдэлээс нөлөөлөх нөлөөллийг зөвлөмж болгон оруулав.

Хүснэгт 1. Физик газарзүйн хувьд үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөлөл байхгүй	Нөлөөллийн эрчим		
			Бага	Дунд	Их
1	Замын трассын дагуу хөрс хуулалт	-			
2	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрс бохирдох	-			
3	Тээврийн хэрэгслээс гарах агаарын бохирдол	-			
4	Тээврийн хэрэгслээс гарах дуу чимээ	-			

Тайлбар: (0) нөлөөлөлгүй
(-) бага сөрөг нөлөөлөлтэй
(-) дунд сөрөг нөлөөлөлтэй
(-) их сөрөг нөлөөлөлтэй
(+) эерэг нөлөөлөлтэй

Бага сөрөг нөлөөлөлтэй	-	-	0 %
Дунд сөрөг нөлөөлөлтэй	-	2	50 %
Их сөрөг нөлөөлөлтэй	-	2	50 %
Эерэг нөлөөлөлтэй	+	0	0.0 %
Нөлөөлөл байхгүй	0	0	0.0 %

Зөвлөмж

- Батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, ашиглах газрын хэмжээг зөрчих, өөр зориулалтаар үйл ажиллагаа явуулах, барилга барихыг хориглоно.
- Хөрсийг аль болох сэндчилж ухахаас сэргийлэх
- Хүчтэй эвдэрсэн газрын хөрсийг сэргээхэд олон настын үрийг хавар бороо орохоос өмнө угтуулж, хөрсөнд цацаж, хүн, малын нөлөөллөөс хамгаалах
- Гал түймрийн аюулаас ямагт сэрэмжилж, урьдчилсан арга хэмжээ төлөвлөн галын хор, элсний нөөцийг нэмэгдүүлэх.
- Түр замыг бороожуулах
- Тэмдэг тэмдэглэгээг сайжруулах
- Малын гарц гармыг тодотгож өгөх

БҮЛЭГ 3. УУР АМЬСГАЛ.

3.1. Уур амьсгал

Байгаль орчны эмзэг тогтоцтой, эрс тэс уур амьсгал нь байгаль орчны болон нийгэм эдийн засгийн амьдралд сөрөг нөлөө үзүүлж байна. Эрт дээр үеэс дан ганц нүүдлийн мал аж ахуйг эрхэж байсан нь байгаль орчин, уур амьсгалын нөхцөлтэй шууд холбоотой байсан ба өнөөгийн зах зээлийн чөлөөт эдийн засгийн орчинд газар ашиглалтын олон хэлбэр, зориулалт нэмэгдсэний зэрэгцээ хүн ам, малын тоо нэмэгдсэн нь газар, байгаль, цаг уурт өөрчлөлтөд ихээхэн орж байна. Иймд тухайн сумын уур амьсгалын өнөөгийн төлөв байдал, цаашдын өөрчлөлтийн чиг хандлагыг судлах нь сумын нутаг дэвсгэрийн хөгжлийг чиглүүлэх ач холбогдолтой тул төлөвлөгөөнд тусгаж ашиглах шаардлагатай байна.

Дарьганга сум:

Дарьганга сум монгол орны уур амьсгалын мужлалаар хахирдуу сэрүүвтэр зунтай, хахирдуу зөөлөн өвөлтэй мужид багтана. Жилийн цэлмэг өдрийн тоо 95-110 хоног, хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 120 хоног байдаг. Галлагааны III дугаар мужид хамрагдах бөгөөд галлагааны хугацаа 10 дугаар сарын 15-наас 25-нд эхэлж, 4 дүгээр сарын 15-наас 25-ны хооронд дуусна. Галлагааны хугацаа 196-210 хоног буюу дунджаар 205 хоног үргэлжилнэ. Энэ хугацаанд агаарын температур дунджаар -30 С 50 С байдаг. Тухайн газар орны уур амьсгал нь хамгийн багадаа 30 жил буюу түүнээс урт цуваатай цаг уурын мэдээний дунджаар илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл уур амьсгалын мэдээ нь тухайн газар орны цаг агаарын ерөнхий шинж нь жилийн аль сард ямар байх вэ гэдгийг илэрхийлдэг. Уур амьсгалын мэдээлэлд агаарын температур, хур тунадасны хэмжээ чухал үүрэгтэй байдаг. Тухайн газар орны уур амьсгалын төлөв байдал ямар байх гэдэгт газрын гадаргуугийн өндөршил, газарзүйн өргөрөг, түүнд ойрхон байгаа ус бүхий гадарга, ургамал бүрхэвч, салхины зүг чиг чухал нөлөө үзүүлдэг.

Асгат сум:

Хүйтний улирлын агаарын дундаж температур /2,1/ хэмээс /-21,3/ градус хүйтэн байдаг ба Асгат сум орчмоор 1,2-р саруудад агаарт хамгийн /минимум/ хүйтэн нь /-25,9/ - /-32,5 / градус орчим хүрч хүйтэрдэг. Мөн энэ саруудад хөрсөн дээр минимум нь /-38 /- /-43/ градус орчим хүрдэг байна. Дулааны улирлын агаарын дундаж температур 4.9-21,8° градус орчим дулаан байдаг бөгөөд 6,7-р сард агаарын хамгийн их утга нь 31,8-37,9° градус, хөрсөнд 55-630 градус хүрч халдаг тул агаар хөрсний температурын хэлбэлзэл их байдаг байна. Хоногийн агаарын дундаж температур -5° дайрч хүйтрэхээс эхлээд 5° дайрч дулаарах үеийг өвлийн улиралд тооцдог. 11-р сарын 1-5-ны орчимд -5° дайрч хүйтрэн өвөл эхэлж , 3-р сарын 20-23 хооронд -5° дайрч дулааран хавар болдог буюу 142-147 хоног буюу 4 сар гаруй өвөл үргэлжилдэг. Бэлчээрийн ургамлын ургах боломжтой хугацаа нь 172-176 хоног буюу хүйтрэлгүй үе ургамал ургах хугацааны 5° градусаас дээших идэвхтэй температурын нийлбэр 2000-2200°С байна. Хуурай дулаавтар уур амьсгалтай бүсэд багтдаг. Хуурай хөрснөөс агаарт ууршиж чийг бага учраас жилийн дулаан улирлын дундаж харьцангуй чийгшил 45 65% байдаг. Тус аймгийн нутагт олон жилийн дунджаар 200.6 мм тунадас орох боловч гантай жил 101.5-111.5 мм болж эрс багасдаг байна. Хүйтний улирал болох 1-3, 10-12 дугаар саруудад хамгийн бага тунадас дунджаар 1.5-10.5 мм, дулааны улирал болох 4-9 дүгээр саруудад дунджаар 4.9-56.7 мм тунадас ордог байна. Салхины дундаж хурд 2.7-4.6 м/с байдаг. Салхины горимын явцаас харахад хавар, намартаа салхины

хурд ихсэж, зун өвөлдөө буурдаг зүй тогтолтой байна. Салхины зонхилох хурд Баруун хойноос 37.1%, Баруунаас 17.8%, Зүүн хойноос 14.5%-тай ихэвчлэн салхилдаг. Цаг агаарын онц аюултай үзэгдэл болох 40 м/с-ээс дээш хүчтэй салхи хавар 4, 5 дугаар сард ажиглагддаг боловч нийт хүчтэй салхины 2%-ийг эзэлдэг. Харин 3, 4 дүгээр сард 16 м/с дээш хүчтэй салхи 15-23 орчим өдөр ажиглагддаг нь тус нутаг салхи шуурга ихтэй бүс нутагт хамрагддаг байна.

3.2.Хур тунадас[1]

Асгат сум:

Сумын нутаг хуурайдуу уур амьсгалтай бүсэд багтана. Агаарт хуурай хөрснөөс ууршиж чийгийн нөөц бага учраас жилийн дулаан улирлын дундаж харьцангуй чийгшил 30-60 хувь хүрнэ. 30 хувиас бага чийгтэй өдрийн тоо 51-62 өдөр байна. Зарим өдөр харьцангуй чийг 6-10 хувь хүртэл буурах явдал бий. Агаар хуурайдуу учир хур тунадасны хэмжээ жилд 108.7-280.6 мм хэмжээтэй орно.

Олон жилийн дунджаар 200.6 мм тунадас орох боловч гантай жил 101.5-111.5 мм болж эрс багасдаг байна. Хүйтний улирал болох 1-3, 10-12 дугаар саруудад хамгийн бага тунадас дунджаар 1.5-10.5 мм, дулааны улирал болох 4-9 дүгээр саруудад дунджаар 4.9-56.7 мм тунадас ордог байна.

Хүснэгт 2. Хур тунадасны нийлбэр, мм

Он	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Нийлбэр
2020	0.9	0	0	2.4	72.9	34	43	0	62	21.3	3.3	2.4	241.9
2021	2.7	1.3	0	4.4	4	4.1	44	45	13	0.3	2.6	0	120.9
2022	5.6	0.9	0.6	20.6	2.5	0.8	62	64	38	1.1	2	0	198.2
2023	0.6	0.2	0.6	5.4	25.8	11	54	76	12	2.6	1.6	3.7	194.1
2024	0	0.2	0.2	0.8	31	22	71	98	1.9	9.1	11.6	0	245.3
Дундаж	1.96	0.52	0.28	6.72	27.2	14	55	56	25	6.88	4.22	1.22	200.08

Өвөл, зуны байгаль, цаг уурын хамгийн тохиромжтой нөхцөлд малын ашиг шим, удамшлын чадамж дээд зэргээр илэрдэг. Харин, цаг уурын тохиромжтой нөхцөл өөрчлөгдөх нь мал сүрэгт сөргөөр нөлөөлж тарга хүч, ашиг шим нь муудах ялангуяа дасан зохицох чадварын хэмжээнээс хэтэрвэл үхэж хорогддог байна (Төмөржав, 2004, Туваансүрэн нар, 1996).

Дарьганга сум:

Сүхбаатар аймгийн нутаг хуурайдуу уур амьсгалтай бүсэд багтана. Агаарт хуурай хөрснөөс ууршиж чийгийн нөөц бага учраас жилийн дулаан улирлын дундаж харьцангуй чийгшил 30-60 хувь хүрнэ. 30 хувиас бага чийгтэй өдрийн тоо 51-62 өдөр байна. Зарим өдөр харьцангуй чийг 6-10 хувь хүртэл буурах явдал бий. Агаар хуурайдуу учир хур тунадасны хэмжээ жилд 108.7-280.6 мм хэмжээтэй орно.

Олон жилийн дунджаар 200.6 мм тунадас орох боловч гантай жил 101.5-111.5 мм болж эрс багасдаг байна. Хүйтний улирал болох 1-3, 10-12 дугаар саруудад хамгийн бага тунадас дунджаар 1.5-10.5 мм, дулааны улирал болох 4-9 дүгээр саруудад дунджаар 4.9-56.7 мм тунадас ордог байна.

[1] *Дорнод аймгийн Ус, цаг, уур орчны шинжилгээний төв*

Хүснэгт 3. Хур тунадас, Баяндэлгэр өртөө, мм, 2020-2024 он

Он	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Нийлбэр
2020	0.9	0	0	2.6	72.7	32	45	0	61	21.5	3.5	2.4	243.4
2021	2.7	1.3	0	4.4	4	4.1	44	45	13	0.3	2.6	0	120.9
2022	5.6	0.9	0.6	20.6	2.5	0.8	62	64	38	1.1	2	0	198.2
2023	0.6	0.2	0.6	5.4	25.8	11	54	76	12	2.6	1.6	3.7	194.1
2024	0	0.2	0.2	0.8	31	21	72	96	1.7	9.1	11.2	0	242.7
Дундаж	1.96	0.52	0.28	6.72	27.2	14	55	56	25	6.88	4.22	1.22	200.08

Өвөл, зуны байгаль, цаг уурын хамгийн тохиромжтой нөхцөлд малын ашиг шим, удамшлын чадамж дээд зэргээр илэрдэг. Харин, цаг уурын тохиромжтой нөхцөл өөрчлөгдөх нь мал сүрэгт сөргөөр нөлөөлж тарга хүч, ашиг шим нь муудах ялангуяа дасан зохицох чадварын хэмжээнээс хэтэрвэл үхэж хорогддог байна (Төмөржав, 2004, Туваансүрэн нар, 1996).

3.3.Агаарын температур[2]

Дарьганга сум:

Тухайн газар орны уур амьсгал нь хамгийн багадаа 30 жил буюу түүнээс урт цуваатай цаг уурын мэдээний дунджаар илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл уур амьсгалын мэдээ нь тухайн газар орны цаг агаарын ерөнхий шинж нь жилийн аль сард ямар байх вэ гэдгийг илэрхийлдэг. Уур амьсгалын мэдээлэлд агаарын температур, хур тунадасны хэмжээ чухал үүрэгтэй байдаг. Тухайн газар орны уур амьсгалын төлөв байдал ямар байх гэдэгт газрын гадаргуугийн өндөршил, газарзүйн өргөрөг, түүнд ойрхон байгаа ус бүхий гадарга, ургамал бүрхэвч, салхины зүг чиг чухал нөлөө үзүүлдэг.

Хүснэгт 4. Дарьганга сумын агаарын температурын олон жилийн дундаж статистик үзүүлэлтүүд

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Дундаж	-22	-17	-7.3	3.3	10.9	17	20.1	18.5	11.9	2.2	-9.6	-19	0.7
Стан/хазайлт	3	2.9	2.7	2.3	1.6	1.9	1.7	1.5	1.7	1.7	2.5	2.1	2.1
Тох/тоо	29	30	30	30	30	30	30	28	30	30	28	25	29
Үнэм/их	-0.1	9	20.2	27.6	33.5	36	39	38	34	27.2	14	5.4	39
Үнэм/бага	-44	-38	-30	-24	-9.9	-1.9	3.1	1.2	-9.6	-24	-31	-40	-44.8
Тох/тоо	35	35	35	35	35	35	35	35	35	35	35	35	35



Зураг 7. Дарьганга сумын агаарын температурын олон жилийн дундаж

[2] *Сүхбаатар аймгийн Ус, цаг, уур орчны шинжилгээний төв*

Сарын дундаж үнэмлэхүй их, үнэмлэхүй бага температур.

Тухайн сарын өдөр бүр ажиглагдсан үнэмлэхүй их температурын утгуудыг хооронд нэмж, гарсан утгыг тухайн сард оногдох өдрийн тоонд хуваж илэрхийлнэ. Сарын дундаж үнэмлэхүй бага температур нь дээрхтэй адилхан буюу тухайн сарын өдөр бүрийн үнэмлэхүй бага температурыг хооронд нь нэмж гарсан утгыг тухайн сард оногдох өдрийн тоонд хуваана. Үнэмлэхүй их температурын хамгийн өндөр утга өдрийн цагт нартай үед, үнэмлэхүй бага температурын хамгийн бага утга шөнийн цагт, үүрээр нар мандахаас өмнө ажиглагддаг.

Хүснэгт 5. Асгат сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм, 1991-2024 он

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Агаарын үнэмлэхүй их температур	-0.1	9	20.2	27.6	33.5	36	39	38	34	27.2	14	5.4	39
Агаарын үнэмлэхүй бага температур	-44.8	-38	-30.6	-24.8	-9.9	-1.9	3.1	1.2	-9.6	-24.5	-31.4	-40.2	-44.8



Зураг 8. Дарьганга сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм

Асгат сум:

Уур амьсгалын ерөнхий төлөв буюу горимыг хамгийн багадаа 30 жил буюу түүнээс урт цуваатай цаг уурын мэдээний дунджаар илэрхийлдэг.

Тухайн сарын өдөр бүр ажиглагдсан үнэмлэхүй их температурын утгуудыг хооронд нэмж, гарсан утгыг тухайн сард оногдох өдрийн тоонд хуваж илэрхийлнэ. Сарын дундаж үнэмлэхүй бага температур нь дээрхтэй адилхан буюу тухайн сарын өдөр бүрийн үнэмлэхүй бага температурыг хооронд нь нэмж гарсан утгыг тухайн сард оногдох өдрийн тоонд хуваана. Үнэмлэхүй их температурын хамгийн өндөр утга өдрийн цагт нартай үед, үнэмлэхүй бага температурын хамгийн бага утга шөнийн цагт, үүрээр нар мандахаас өмнө ажиглагддаг.

Асгат сумын нутгаар агаарын температурын олон жилийн дундаж нь (+1.600 С) байгаа нь агаарын температурын хувьд сэрүүвтэр бүсэд хамаарагдахыг харуулна. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын температур нийт сумдын нутгаар -10С-аас -4.800 С-ын хооронд хэлбэлзэх ба үнэмлэхүй бага утга нь -44.80 С хүрсэн байна. Хавар 000 С-ыг

давж дулаарах хугацаа 3 дугаар сарын сүүлчийн арав хоногт тохиолдох ба дунджаар 7-р сард хамгийн дулаан буюу 18.00 С-аас 23.600 С-ын хооронд, дундаж утга нь 20.800 С байна.

Хүснэгт 6. Асгат сумын агаарын температурын олон жилийн дундаж статистик үзүүлэлтүүд

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Дундаж	-21	-16	-6.8	4.2	12.2	18.6	21.2	18.9	12.4	2.6	-9.9	-18	1.5
Стан/хазайлт	2.8	3	2.7	2.2	1.9	2.2	1.8	1.9	1.5	1.5	2.4	2.3	2.2
Тох/тоо	28	28	26	26	25	26	26	30	28	26	29	27	27
Үнэм/их	-0.1	7.5	22.2	29.8	35.5	38.8	40.8	39.2	33.9	31	15.6	5.2	40.8
Үнэм/бага	-41	-37	-32	-20	-9.5	0.5	4.9	-2.5	-8.8	-28	-34	-38	-41
Тох/тоо	27	27	23	24	24	25	25	27	26	24	27	26	25



Зураг 9. Асгат сумын агаарын температурын олон жилийн дундаж

Сарын дундаж үнэмлэхүй их, үнэмлэхүй бага температур.

Тухайн сарын өдөр бүр ажиглагдсан үнэмлэхүй их температурын утгуудыг хооронд нэмж, гарсан утгыг тухайн сард оногдох өдрийн тоонд хуваж илэрхийлнэ. Сарын дундаж үнэмлэхүй бага температур нь дээрхтэй адилхан буюу тухайн сарын өдөр бүрийн үнэмлэхүй бага температурыг хооронд нь нэмж гарсан утгыг тухайн сард оногдох өдрийн тоонд хуваана. Үнэмлэхүй их температурын хамгийн өндөр утга өдрийн цагт нартай үед, үнэмлэхүй бага температурын хамгийн бага утга шөнийн цагт, үүрээр нар мандахаас өмнө ажиглагддаг.

Хүснэгт 7. Асгат сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм, 1991-2024 он

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Агаарын үнэмлэхүй их температур	-0.1	7.5	22.2	29.8	35.5	38.8	40.8	39.2	33.9	31.0	15.6	5.2	40.8
Агаарын үнэмлэхүй бага температур	-41.9	-37.9	-32.8	-20.1	-9.5	0.5	4.9	-2.5	-8.8	-28	-34.8	-38.2	-41.9



Зураг 10. Асгат сумын агаарын үнэмлэхүй их, бага температурын норм

3.4. Салхи, салхины чиглэл[3]

Дарьганга сум:

Монгол орны зонхилох салхины нөлөө, мөн чийгийн дутмагшлаас үүдэн энэ орчмын нутагт салхины нөлөө ихтэй. Энэ ихэвчлэн 4-6 саруудад ихээхэн ажиглагдана. Гэхдээ бусад саруудаа ч гэсэн салхины хурд тогтмол байх хандлага бий.

Хүснэгт 8. Баяндэлгэр өртөө, Салхины дундаж хурд м/с /2020-2024/

Он	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Нийлбэр
2020	3.7	4.5	4.5	4.9	5.8	2.9	2.5	3	2.4	2.9	3.5	3.4	44
2021	3	3	3.1	4.6	5.1	2.6	3.1	2.4	3.5	2.8	3.5	3.4	40.1
2022	3.2	3.7	4.1	4.5	5.4	2.8	2.6	2.7	2.3	2.7	3.4	3.2	40.6
2023	4	3	3.9	3.6	5.5	5.2	2.7	2.8	2.9	4.2	3.3	3.3	44.4
2024	1.9	3.2	4.2	3.9	4.7	3.3	2.1	2.3	2.8	4.3	3.3	3.5	39.5
Дундаж	3.16	3.48	3.96	4.3	5.3	3.36	2.6	2.64	2.78	3.38	3.4	3.36	41.72

Зураг 11. Баяндэлгэр өртөө, салхины дундаж хурд м/с 2016-2020 оны дунджаар

[3] *Дорнод аймгийн Ус, цаг, уур орчны шинжилгээний төв*

Асгат сум:

Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, агаарын даралт, тухайн нутгийн физик газар зүйн нөхцөлөөс ихээхэн шалтгаалдаг.

Хүснэгт 9. Баяндэлгэр өртөө, Салхины дундаж хурд м/с /2020-2024/

Он	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Нийлбэр
2020	3.7	4.5	4.5	4.9	5.8	2.9	2.5	3	2.4	2.9	3.5	3.4	44
2021	3	3	3.1	4.6	5.1	2.6	3.1	2.4	3.5	2.8	3.5	3.4	40.1
2022	3.2	3.7	4.1	4.5	5.4	2.8	2.6	2.7	2.3	2.7	3.4	3.2	40.6
2023	4	3	3.9	3.6	5.5	5.2	2.7	2.8	2.9	4.2	3.3	3.3	44.4
2024	1.9	3.2	4.2	3.9	4.7	3.3	2.1	2.3	2.8	4.3	3.3	3.5	39.5
Дундаж	3.16	3.48	3.96	4.3	5.3	3.36	2.6	2.64	2.78	3.38	3.4	3.36	41.72

БҮЛЭГ 4. АГААРЫН ЧАНАР.

4.1. Танилцуулга

Энэхүү бүлэгт төслийн талбай нь агаарын чанарын суурь нөхцөлийг тодорхойлох зорилгоор 2025 оны 07-р сарын 17-ний өдөр "Тэкол" ХХКомпанийн судалгааны баг төслийн талбайд ажилласан. Уг судалгааны ажлын үр дүнг энэ хэсэгт нарийвчлан тусгав.

4.2. Судалгааны арга зүй

Хээрийн судалгааны маягтад дараах мэдээллүүдийг тэмдэглэсэн. Үүнд:

- ✓ Солбицол (UTM, WGS 84, 48N),
- ✓ Хэмжилт хийсэн огноо,
- ✓ Салхины хурд, м
- ✓ PM10, PM2.5-ын хэмжилтийн үр дүнгүүд зэрэг болно.

Төслийн талбай, түүний орчмын агаар дахь том, жижиг ширхэглэгт тоосонцрууд (PM2.5, PM10)-ын хэмжилтийг DustTrak TSI 8520 маркийн багаж ашиглан талбайд сонгон авсан 4 цэг тус бүрд 2 цагийн хийсэн.

Зураг 12. Тоосонцрын хэмжилтийн багаж DustTrak T SI 85

Өнөөдрийн байдлаар агаар дахь түгээмэл бохирдуулагч бодисуудыг тодорхойлох ажил Улаанбаатар хотоос бусад газарт хийгддэггүй бөгөөд зөөврийн дээжлэг чийг ханган нийлүүлэгч байхгүйн улмаас дээж авч, лабораторид шинжлэх боломжгүй байв.

4.3. Судалгааны үр дүн

Төслийн талбайд хийсэн агаар дахь тоосонцрын хэмжилтийн үр дүнг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага (MNS 4585:2016) стандарттай харьцуулан дүгнэв.

Хүснэгт 10. Төслийн талбайн агаар дахь PM 10 болон PM 2.5 тоосонцрын агууламж, мг/м3

№	Байрлал	Координат	PM 10 тоосонцор			PM 2.5 тоосонцор		
			их	бага	дундаж	их	бага	дундаж
1	Замын эхлэл	46°02'31.22" 114°21'28.42"	54	32	43	22	8	15
2	Замын дунд хэсэг	45°57'10.29" 114°22'50.12"	34	27	30.5	21	7	14
3	Замын дунд хэсэг	45°46'04.42" 114°30'17.08"	34	27	30.5	21	7	14
4	Замын дунд хэсэг	45°20'05.99" 113°54'24.86"	41	31	38	20	8	14
5	Замын төгсгөл	45°18'13.27" 113°52'12.7"	36	33	34.5	23	9	16
MNS 4585:2016		**Хүлцэх агууламж мкг/м^3**			**100.0**			**50.0**

4.4. Дүгнэлт, зөвлөмж

Дээрх үр дүнгээс үзэхэд "Кеаро" ХХКомпанийн "Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам"-ын зураг төслийн авто замын трассын дагуу агаар дахь тоосонцрын хэмжээ "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016" стандартад заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

- Төслийн талбайн дотоод болон гадаад орчны агаарын чанарыг тодорхойлох зорилгоор жилд 3 удаа агааараас сорьц авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, заавар зөвлөмж авч ажиллах;
- Төслийн талбайн барилгын ажлын үед pm10, pm2.5 стандартаас их байх болохоор түр зам болон даланг бороожуулах шаардлагатай



Зураг 13. Хэмжилт хийсэн байршлууд

БҮЛЭГ 5. ФИЗИК БОХИРДОЛ

5.1. Танилцуулга

Энэхүү бүлэгт дуу шуугианы суурь түвшнийг тодорхойлох зорилгоор 2025 оны 07-р сарын 17-ний өдөр төслийн талбайд хийсэн хээрийн болон суурин судалгааны үр дүнг дэлгэрэнгүй тусгалаа.

5.2. Судалгааны арга зүй

Төслийн талбай, түүний орчимд нийт 4 цэг дээр дуу шуугианы хэмжилт хийсэн. Судалгаанд Digital Sound Level Meter багажийг ашигласан.

Зураг 14. Дуу шуугиан хэмжигч багаж

Хэмжилтийг хийхдээ багажийг газрын гадаргаас дээш 1.5 м-ийн зайд, салхины эсрэг байрлуулан 2 цагийн турш хэмжсэн. Нийт 4 удаагийн хэмжилтийн дунджаар тухайн орчны дуу шуугианы түвшнийг тодорхойлсон.

Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016) стандартад заасанчлан өдрийн цагт 60 дБА (2 цагийн дунджаар), шөнийн цагаар 45 дБА (2 цагийн дунджаар)-аас хэтрүүлэхгүй байх ёстой.

5.3. Судалгааны үр дүн

Хүснэгт 11. Төслийн талбайд хийгдсэн дуу шуугианы хэмжилтийн үр дүн

№	Цэгийн байршил		Шуугианы түвшин (16 цагийн дундаж)
	Өргөрөг	Уртраг	
1	46°02'31.22"	114°21'28.42"	42.2
2	45°57'10.29"	114°22'50.12"	39.9
3	45°46'04.42"	114°30'17.08"	40.8
4	45°20'05.99"	113°54'24.86"	41.7
5	45°18'13.27"	113°52'12.7"	42.6

Дүгнэлт

Дээрх хүснэгтээс үзэхэд төслийн талбай дотор авсан дуу шуугианы хэмжээ 39.9-42.6 дБА байгаа нь MNS 4585:2016 Агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.

БҮЛЭГ 6. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ БА ГЕОМОРФОЛОГИ

6.1. Геологийн тогтоц

Дарьганга сум:

Инженер геологийн нөхцөлийг тодорхойлохдоо "Монгол орны одоо байгаа төрөл бүрийн масштабтай зураг / геологи, геоморфологи, гадаргын хэрчигдэл, шинэ тектоник, газар чичирхийлэл, ашигт малтмал, инженер-геологийн нөхцөл, мужлал, онцгой шинж чанар бүхий ул хөрс, газар хөдлөл, цэвдэг, гидрогеологи, гидрологи, түүх археологи/-ын тоон өгөгдлийн санг нэгдсэн арга зүй программ хангамж, стандартын дагуу нэгтгэж орон зайн мэдээллийн дэд бүтцийн гео-системийн давхарга байгуулах" төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн инженер-геологийн өргөтгөсөн судалгааг "Инжгеотех" ХХК-ийн мэргэжлийн баг хийж гүйцэтгэсэн тайлангийн мэдээллийг ашиглав. *("Инжгеотех", 2014 он)*

Дарьганга сумын төвийн инженер геологийн нөхцөл

Геологийн тогтцыг дээд неогены настай хүрмэн чулуу болон дөрөвдөгчийн настай, делювийн гаралтай сэвсгэр хурдас тодорхойлно. Голлох хөрс нь хайр, хайрга агуулсан шавранцар, дунд ширхэгтэй элс, тоосорхог элсэн хөрс байдаг. Неогены настай хүрмэн чулуулаг болон дөрөвдөгчийн настай делювийн гаралтай хөрсүүдийг нас, гарал үүсэл, ширхгийн бүрэлдэхүүн, физик-механик шинж чанараас нь хамааран инженер-геологийн 5 элемент болгон авч үзлээ. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай, делювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /dQ2/

ИГЭ-1. Хайр, хайрга агуулсан шавранцар хөрс Бор ногоон өнгөтэй хатуу консистенцтэй, хайр, хайрга агуулсан шавранцар хөрс нь 5.7 м хүртэл зузаантайгаар сумын төвийн хэмжээнд бүхэлд нь жижиг болон дунд ширхэгтэй элс, тоосорхог элсэн хөрсөөр хучигдан тархсан байна.

ИГЭ-2. Дунд ширхэгтэй элсэн хөрс Цайвар шар өнгөтэй, бага чийгтэй, дунд ширхэгтэй элсэн хөрс нь 2.2 м хүртэл зузаантайгаар сумын төвийн төв хэсгээр багахан талбайд хайр, хайрга агуулсан шавранцар хөрсийг хучин тогтсон байна.



Зураг 15. Сумын инженер геологийн нөхцөл

ИГЭ-3. Жижиг ширхэгтэй элсэн хөрс Цайвар шар өнгөтэй, бага чийгтэй жижиг ширхэгтэй элсэн хөрс нь 2.4 м хүртэл зузаантай сумын төвийн төв хэсгээр хайр, хайрга агуулсан шавранцар хөрсийг хучин тогтсон байна.

ИГЭ-4. Тоосорхог элсэн хөрс Цайвар шар өнгөтэй, бага чийгтэй тоосорхог элсэн хөрс нь 3.1 м хүртэл зузаантайгаар сумын төвийн баруун болон зүүн хэсгээр хайр, хайрга агуулсан шавранцар хөрсийг хучин тогтсон байна. Неогены настай, баяхмал гаралтай хүрмэн чулуулгийн геологи-гарал үүслийн комплекс /βN1-2/

ИГЭ-4. Хүрмэн чулуу Хүрмэн чулуу нь сумын төвийн хэмжээнд хойд хэсгээр хоёрдугаар комплекс болгон зураглагдсан байна.

Асгат сум:

Инженер геологийн нөхцөлийг тодорхойлохдоо "Монгол орны одоо байгаа төрөл бүрийн масштабтай зураг / геологи, геоморфологи, гадаргын хэрчигдэл, шинэ тектоник, газар чичирхийлэл, ашигт малтмал, инженер-геологийн нөхцөл, мужлал, онцгой шинж чанар бүхий ул хөрс, газар хөдлөл, цэвдэг, гидрогеологи, гидрологи, түүх археологи/-ын тоон өгөгдлийн санг нэгдсэн арга зүй программ хангамж, стандартын дагуу нэгтгэж орон зайн мэдээллийн дэд бүтцийн гео-системийн давхарга байгуулах" төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн инженер-геологийн өргөтгөсөн судалгааг "Инжгеотех" ХХК-ийн мэргэжлийн баг хийж гүйцэтгэсэн тайлангийн мэдээллийг ашиглав. ("Инжгеотех", Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн инженер-геологийн өргөтгөсөн судалгаа, 2014 он)

Асгат сумын төвийн инженер геологийн нөхцөл

Карбоны настай гүний гаралтай боржин чулуулаг болон дээд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай үүсэлтэй сэвсгэр хучаас хурдас тодорхойлно. Голлох хөрс нь сайргархаг элсэн хөрс, хайргархаг, шавранцар байна. Карбоны настай гүний гаралтай боржин чулуулаг болон дөрөвдөгчийн настай сэвсгэр хөрсүүдийг инженер-геологийн 4 элемент байна. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай, делюви-пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /dpQ2/

ИГЭ-1. Сайргархаг элсэн хөрс Бор шаргал, бор саарал өнгөтэй бага чийгтэй сайргархаг элсэн хөрс нь 4.8 м хүртэл зузаантайгаар сумын төвийн баруун урд болон зүүн хойд хэсгээр бага хэмжээгээр тархан .

ИГЭ-2. Хайргархаг шавранцар хөрс Улаан хүрэн, бор хүрэн өнгөтэй, хатуу консистенцтэй, хайргархаг шавранцар хөрс нь 3.3 м хүртэл зузаантайгаар сумын төвийн .

ИГЭ-3. Хайргархаг шавранцар хөрс Улаан хүрэн, бор хүрэн өнгөтэй, хатуу консистенцтэй, шавран хөрс нь 4.0 м хүртэл зузаантайгаар сумын төвийн баруун хойд болон баруун урд хэсгээр сайргархаг элсэн хөрс, шавранцар хөрсөөр хучигдан тогтсон байна. Карбоны настай, гүний гаралтай чулуулгийн геологи-гарал үүслийн комплекс /γC1-2/

ИГЭ-4. Боржин чулуу Карбоны настай гүний гаралтай боржин чулуулаг нь сумын төвийн хэмжээнд бүхэлд нь дөрөвдөгчийн сэвсгэр хурдасаар хучигдан хоёрдугаар комплексд ялгагддаг.



Зураг 16. Асгат сумын төвийн инженер геологийн нөхцөл



Зураг 17. Геоморфологийн дэвсгэр зураг

БҮЛЭГ 7. ГАДАРГЫН УС

7.1 Гадаргын ус

Дарьганга сум:

Дарьганга сумын нутаг дэвсгэрийн 3.3% нь Галба-Өөш-Долоодын сав газар, 2.5% нь Мэнэнгийн тал сав газарт хамаарч байна.

Хүснэгт 12. Усны сав газрын үзүүлэлт

Сумын нэр	Сав газрын эр	Талбай /га/
Дарьганга сум	Галба-Өөш-Долоодын сав газар	274063.5
	Мэнэнгийн тал сав газар	206765.4

Мэнэнгийн тал сав газар: Дорнод Монголын өргөн уудам тал нутгийн дунд орших Мэнэнгийн тал нь тэгш тал бөгөөд ийм талын гадарга жигд, налуу нь 10 м/км-ээс хэтэрдэггүй. Мэнэнгийн тал нь Буйр нуураас баруун тийш 90 гаруй км урт, 60 гаруй км өргөн нутгийг эзлэн д.т.д 600 м өндөрт орших манай орны хамгийн том тэгш тал юм.



Зураг 18. Гадаргын усны зураг

Номхон далайн ай савд багтах бөгөөд байнгын урсгалтай гол мөрөн байхгүй,газрын доорх усны нөөцтэй бүс нутаг.

Хил заагийн хувьд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум бүхэлдээ, Сүхбаатар сумын зүүн урд хэсэг, Асгат сумын зүүн болон зүүн урд хэсэг, урд хэсэг, Дарьганга сумын зүүн хойд хэсэг, Дорнод аймгийн Матад сум бүхэлдээ, Халхгол сумын баруун хэсэг, Баянтүмэн зүүн урд хэсэг, Булган зүүн урд хэсгийг багтаан нийтдээ 53371.6 км2 талбайг эзэлдэг.

Усны сан бүхий газрын ашиглалт хамгаалалт, тооллого, судалгаа

Монгол улсын Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4.-т "усны сан бүхий газар" гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг; хэлнэ гэж тодорхойлсон.

Мөн энэ хуулиар усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтоох, усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтоохоор хуульчилсан.

Усны сан бүхий газрын өнөөгийн ашиглалтын талаар сумын хэмжээнд нийт 52 нуур, 24 гол, булаг, 101 худаг байна. Мөн улирлын чанартай хурын уснаас шалтгаалан ширгэж, үүсдэг жижиг нуурууд байна. *(БОАЖЯ, Усны сав газрын захиргаа, 2020-2021 он)*

Асгат сум:

Монгол орны нийт нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хуваажүздэг бөгөөд Асгат сумын нутаг дэвсгэр нь Мэнэнгийн тал, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар, Галба-Өөш-Долоодын сав газарт хамаарч байна.

Хүснэгт 13. Усны сав газрын үзүүлэлт

Сумын нэр	Сав газрын эр	Талбай /га/
Асгат сум	Мэнэнгийн тал	415795.4
	Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар	212953.8
	Галба-Өөш-Долоодын сав газар	92114.1

Мэнэнгийн тал сав газар: Дорнод Монголын өргөн уудам тал нутгийн дунд орших Мэнэнгийн тал нь тэгш тал бөгөөд ийм талын гадарга жигд, налуу нь 10 м/км-ээс хэтэрдэггүй. Мэнэнгийн тал нь Буйр нуураас баруун тийш 90 гаруй км урт, 60 гаруй км өргөн нутгийг эзлэн д.т.д 600 м өндөрт орших манай орны хамгийн том тэгш тал юм.

Номхон далайн ай савд багтах бөгөөд байнгын урсгалтай гол мөрөн байхгүй,газрын доорх усны нөөцтэй бүс нутаг.

Хил заагийн хувьд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум бүхэлдээ, Сүхбаатар сумын зүүн урд хэсэг, Асгат сумын зүүн болон зүүн урд хэсэг, урд хэсэг, Дарьганга сумын зүүн хойд хэсэг, Дорнод аймгийн Матад сум бүхэлдээ, Халхгол сумын баруун хэсэг, Баянтүмэн зүүн урд хэсэг, Булган зүүн урд хэсгийг багтаан нийтдээ 53371.6 км2 талбайг эзэлдэг.



Зураг 19.Гадаргын усны зураг

Усны сан бүхий газрын ашиглалт хамгаалалт, тооллого, судалгаа

Монгол улсын Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4.-т "усны сан бүхий газар" гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг; хэлнэ гэж тодорхойлсон.

Мөн энэ хуулиар усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтоох, усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтоохоор хуульчилсан.

Усны сан бүхий газрын өнөөгийн ашиглалтын талаар сумын хэмжээнд нийт 17 нуур, 10 гол, булаг, 186 худаг байна. Мөн улирлын чанартай хурын уснаас шалтгаалан ширгэж, үүсдэг жижиг нуурууд байна. *(БОАЖЯ, Усны сав газрын захиргаа, 2020-2021 он)*

БҮЛЭГ 8. ГАЗРЫН ДООРХ УС

8.1. Судлагдсан байдал

Асгат сум:

Монгол орны газрын доорх ус орчин үеийн болон эртний янз бүрийн насны хурдас чулуулагт агуулагдана. Газрын доорх ус орших байдлаараа нүх сүвийн, ан цавын гэсэн үндсэн хоёр хэв шинжид хуваагдана. Гидрогеологийн мужлалаар улирлын хомс хангалттай, Дорноговийн мужид багтана. Шинэ төрмөлийн үеийн бялхмал чулуулгийн нэгэн хэлбэр шүлтлэг хүрмэн чулуулагт агуулагддаг газрын гүний ус нь ерөнхийдөө эрдэсжилт ихтэй байдаг. Элсний хонхор, түүний орчны тал газар тааралдах булаг, гар худгийн ус ундарга багатай, цагт ойролцоогоор 15-20 л ус хуримтлагдах нөөцтэй байдаг.

Газрын доорх усны нөөц жигд бус тархалттай, хойноос урагшлах тутам түүний тархалт алаг цоог болж, эрдэсжилт нь ихсэх хандлага ажиглагдана. Энэ нь хойноос урагшлах тутам хур тунадасны хэмжээ багасах, агаарын температур, ууршил нэмэгдэх зэргээр уур амьсгалын нөхцөл өөрчлөгддөгөөс голчлон шалтгаална. Газрын доорх усны нөөц бүрэлдэх процесст хур тунадас, усны уурын өтгөрөл, тектоник хагарлын тогтоц, ялангуяа бүс нутгийн шинжтэй томоохон хагарал нөлөө үзүүлнэ. Голын урсцын гидрографыг ялгах замаар газрын доорх усны эзлэх хувийг тогтоодог. Газрын доорх усны их баялаг нөөц нь голын хөндийн аллюви, пролювийн хурдас болон томоохон хотгор газарт тархсан Цэрдийн галавын настай сэвсгэрдүү хурдас, тектоник хагарлын зарим хэсэгт хуримтлагдаж байна.

Усны эх үүсвэрүүдийн нөөцийн эрэл хайгуулын ажил явуулж, улсын хэмжээгээр газрын доорх усны 130 ордыг илрүүлэн нөөцийг нь тогтоосон байдаг.

Гарал үүслийн шинж тэмдгээр нь 3 уст комплексын ялгарал

1. Дөрөвдөгчийн хурдасны уст комплекс
2. Цэрдийн хурдасны уст комплекс
3. Палеозойн хурдасны уст комплекс

Дөрөвдөгчийн хурдасны уст комплексын гадаргуугаас анхлан илрэх хөрсний ус нь зонхилон аллюв-пролюв, делюв-пролювийн гарал үүсэлтэй байна. Ус агуулагч хурдас нь элсэнцэр-, шавранцар чигжээстэй том хэмхдэст хөрс, мөн түүнчлэн элс, элсэнцрийн бага зузаантай линзүүд бүрдүүлнэ.

Цэрдийн уст комплекс сулавтар цементлэгдсэн нуур-аллювийн хурдаст 20-25 м гүнээс гидрокарбонат-натри-кальцийн найрлагатай цэнгэг ус илэрдэг. Энэхүү ус нь гүний боржингийн ан цавын усаар тэжээгдэнэ. Цэрдийн уст комплексийн горим хангалттүй судлагдсан ба усан хангамжийн зориулалтаар ашиглагддаггүй байна. Палеозойн хадан хурдасны уст комплекс ан цавлаг боржингийн массив болон тунамал-бялхмал чулуулгийн үед агуулагдана. Зураглалын талбайн баруун хэсэгт бялхмал болон диоритод хөрсний ус агуулагдах боловч нэг ч цооногт 10-15 м хүртэлх гүнд илрээгүй байна. Өмнөх судлаачдын судалгааны материалаас үзэхэд /Казакова, Маринов ба бусад/ дээд палеозойн бялхмал-тунамал комплекст агуулагдах хөрсний ус 35 м-ээс доош гүнд илэрдэг гэж тогтоожээ Доод пермийн ан цавжсан боржингийн массив дахь ус гадаргуугаас 2.4-24.0 м гүнээс илэрдэг ба хөндийн захаар булаг хэлбэрээр илэрдэг байна. Боржингийн массив усны горим уур амьсгалын хүчин зүйлээс хамаардаг ба агаарын хур тунадас, агаарын чийгийн конденсацын

уснаас тэжээмжээ авдаг байна. Уст үеийн зузаан ойролцоогоор 40-45 м байна. Үүнээс Сүхбаатар аймагт дараах ордууд илэрсэн болно.

Хүснэгт 14. Газрын доорх усны нөөц баялгийн нөхцөлийн шалгуур

Далайн түвшнээс дээших өндөр	Хоттог гүдгэрийн дундаж хэвгий	Геологти тектоник тогтоц /давамгайлах төрлөөр/	Хур тунадас, мм	Гадаргуугийн урсац /жилийн дундаж/, мм	Газрын доорх урсац /жилийн дундаж/, мм	Газрын доорх усны нөхөн сэргээгдэх чадвар	Зонхилон тархсан уст үеийн				Ашиглалтын нөөцийн модуль л/с км2	Газрын доорх хангамшлын нөхцөл
							Үндсэн төрөл	Усжилт	Уст үеийн зузаан, мм	Ус дамжуулах чадвар м/хон		
1000-1500	1.5-3.0	Хоттог kz-Q	155-200	5-10	30-50	Дунд	Q-kz-н ул хөрсний Mz-Kz-н үе	00.5-5.0	5-30	200-300	20-3	Сайн
1500-2000	3.0-6.0	Q-н элс хайрган хуримтлал	200-225	10-50	50-100 >100	Сайн	Q-н зузаан ул хөрсний	1-20.0	10-50	100-500	>3-4	Нэн сайн
2000-5000	6.0-12.0	Q-н хуримтлал, kz-өргөгдөл	225-250	50-100	20-50	Дунд	Q-н ба ан цавт ул хөрсний	0.5-10.0	1-10	50-100	2-3	Дунд
2500-3000	12.0-20.0	Kz-Mz өргөгдөл	250-300	100-200	20-10	Дунд	Q-н ба цавт ул хөрсний тектоник хагарал, судлын	0.1-5.0	2.5	20-50	0.5-1.0	Дунд юм уу муу
3000-4000	20.0	Pz-Mz-Kz өргөгдөл	300-400	200-300	<10	Муу	Ан цавт ул хөрсний тектоник хагарал судлын	0.1-3.0	1-5	5-20	05-аас бага	Маш муу

Хүснэгт 15. Асгат сумын гидрогеологийн нөхцөл

№	Ангилал	Талбай /га/
1	Газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг	207038.55
2	Локал тархалттай ундрага ихтэй эсвэл их тархалттай	4966.15
3	Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг	516391.77

Асгат сумын нутаг дэвсгэр нь гидрогеологийн нөхцөлийн хувьд 207038.55 га талбай газрын доорх локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай чулуулаг, 4966.15 га локал тархалттай ундраг ихтэй эсвэл их тархалттай, 516391.77 га үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг байна. (ГЗБГЗЗГ-н архив, 2014 он)

Дарьганга сум:

Гидрогеологийн нөхцөл

Монгол орны газрын доорх ус орчин үеийн болон эртний янз бүрийн насны хурдас чулуулагт агуулагдана. Газрын доорх ус орших байдлаараа нүх сүвийн, ан цавын гэсэн үндсэн хоёр хэв шинжид хуваагдана. Гидрогеологийн мужлалаар улирлын хомс хангалттай, Дорноговийн мужид багтана. Шинэ төрмөлийн үеийн бялхмал чулуулгийн нэгэн хэлбэр шүлтлэг хүрмэн чулуулагт агуулагддаг газрын гүний ус нь ерөнхийдөө эрдэсжилт ихтэй байдаг. Элсний хонхор, түүний орчны тал газар тааралдах булаг, гар худгийн ус ундарга багатай, цагт ойролцоогоор 15-20 л ус хуримтлагдах нөөцтэй байдаг. Энэ орчимд Дагшин

булаг, Оргих булаг, Дэлгэрэх булаг зэрэг том жижиг найман булагтай.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас баруун хойш 14-15 км. Баруун-Урт хотоос зүүн урагш 180 км зайтай далайн түвшнээс дээш 1070 м өндөрт Рашаантын рашаан байдаг. Баруун хойш урссан Рашаантын голын өмнөд хөвөө дагаж шүүрсэн олон тооны булагтай бөгөөд маш нарийн цагаан наанги шавартай холилдон ундардаг. Лүн, Уу булгийн Цагаан толгой, Эмээлцэгийн Цагаан тогой, Баруун нарт, Зүүн нарт, Хонгор овоо, Дарь овоо зэрэг шинэ төрмөлийн эриний гуравдагч, дөрөвдөгч галавын үед оргилж байсан олон тооны шинэхэн унтарсан галт уулс энэ рашааныг эргэн тойрон 5-6 км зайтай хүрээлнэ. Энэ рашаан галт уулын үнс чандруунаас бүтсэн монтмориолит буюу чандруун шавар гэдэг маш нарийн ширхэгтэй цагаан наанги шавар тунамал хурдас дотроос гардаг. Нэлээд зузаан улаан шавар тунамал хурдастай газрын хөрсөн доороос энэхүү монтмориолит буюу цагаан чандруун шавар түлхэгдэн дов сондуул мэт олон булаг оргилон гарч байдаг.

Газрын доорх усны нөөц жигд бус тархалттай, хойноос урагшлах тутам түүний тархалт алаг цоог болж, эрдэсжилт нь ихсэх хандлага ажиглагдана. Энэ нь хойноос урагшлах тутам хур тунадасны хэмжээ багасах, агаарын температур, ууршил нэмэгдэх зэргээр уур амьсгалын нөхцөл өөрчлөгддөгөөс голчлон шалтгаална. Газрын доорх усны нөөц бүрэлдэх процесст хур тунадас, усны уурын өтгөрөл, тектоник хагарлын тогтоц, ялангуяа бүс нутгийн шинжтэй томоохон хагарал нөлөө үзүүлнэ. Голын урсцын гидрографыг ялгах замаар газрын доорх усны эзлэх хувийг тогтоодог. Газрын доорх усны их баялаг нөөц нь голын хөндийн аллюви, пролювийн хурдас болон томоохон хотгор газарт тархсан Цэрдийн галавын настай сэвсгэрдүү хурдас, тектоник хагарлын зарим хэсэгт хуримтлагдаж байна.

Усны эх үүсвэрүүдийн нөөцийн эрэл хайгуулын ажил явуулж, улсын хэмжээгээр газрын доорх усны 130 ордыг илрүүлэн нөөцийг нь тогтоосон байдаг.

Гарал үүслийн шинж тэмдгээр нь 3 уст комплексын ялгарал

1. Дөрөвдөгчийн хурдасны уст комплекс

2. Цэрдийн хурдасны уст комплекс

3. Палеозойн хурдасны уст комплекс

Дөрөвдөгчийн хурдасны уст комплексын гадаргуугаас анхлан илрэх хөрсний ус нь зонхилон аллюв-пролюв, делюв-пролювийн гарал үүсэлтэй байна. Ус агуулагч хурдас нь элсэнцэр-, шавранцар чигжээстэй том хэмхдэст хөрс, мөн түүнчлэн элс, элсэнцрийн бага зузаантай линзүүд бүрдүүлнэ. Баруун-Урт голын хөндийд хөрсний ус 1,5-1,9 м гүнд илэрнэ. Уст давхаргын зузаан 4-10 м-ийн хооронд хэлбэлзэнэ.

Барилга үйлдвэрийн баазын өмнөх хонхорт делюв-пролювийн хурдаст хөрсний ус 4.5 м гүнд илэрсэн. Энэхүү хөрсний ус нь дээд доод 2 талаасаа ус үл нэвтрүүлэх шавар хөрснөөр хязгаарлагдан даралттай нөхцөлд оршино. Уст үеийн зузаан энэ хэсэгтээ 0,6 м байна. Уст давхарга зуны улиралд агаарын хур тунадасны усаар тэжээгдэх ба үлдсэн хугацаанд палеозойн гүний чулуулаг болон тунамал-бялхмал чулуулгийн урсцаас тэжээмжээ авдаг байна. Хөрсний усны түвшний хэлбэлзлийн агууриг делюв-пролювийн хурдаст 2.5-3.0 м байна.

Цэрдийн уст комплекс сулавтар цементлэгдсэн нуур-аллювийн хурдаст 20-25 м гүнээс гидрокарбонат-натри-кальцийн найрлагатай цэнгэг ус илэрдэг. Энэхүү ус нь гүний боржингийн ан цавын усаар тэжээгдэнэ. Цэрдийн уст комплексийн горим хангалттүй судлагдсан ба усан хангамжийн зориулалтаар ашиглагддаггүй байна. Палеозойн хадан хурдасны уст комплекс ан цавлаг боржингийн массив болон тунамал-бялхмал чулуулгийн үед агуулагдана. Зураглалын талбайн баруун хэсэгт бялхмал болон диоритод хөрсний ус агуулагдах боловч нэг ч цооногт 10-15 м хүртэлх гүнд илрээгүй байна. Өмнөх судлаачдын судалгааны материалаас үзэхэд /Казакова, Маринов ба бусад/ дээд палеозойн бялхмал-тунамал комплекст агуулагдах хөрсний ус 35 м-ээс доош гүнд илэрдэг гэж тогтоожээ Доод пермийн ан цавжсан боржингийн массив дахь ус гадаргуугаас 2.4-24.0 м гүнээс илэрдэг ба хөндийн захаар булаг хэлбэрээр илэрдэг байна. Боржингийн массив усны горим уур амьсгалын хүчин зүйлээс хамаардаг ба агаарын хур тунадас, агаарын чийгийн конденсацын уснаас тэжээмжээ авдаг байна. Уст үеийн зузаан ойролцоогоор 40-45 м байна. Үүнээс Сүхбаатар аймагт дараах ордууд илэрсэн болно. *(ГЗБГЗЗГ, 2014 он)*

Хүснэгт 16. Газрын доорх усны нөөц баялгийн нөхцөлийн шалгуур

Далайн түвшнээс дээших өндөр	Хотгор гүдгэрийн дундаж хэвгий	Геологи тектоник тогтоц /давамгайлах төрлөөр/	Хур тунадас, мм	Гадаргуугийн урсац /жилийн/	Газрын доорх урсац /жилийн дундаж/, мм	Газрын доорх усны нөхөн сэргээгдэх чадвар	Зонхилон тархсан уст үеийн				Ашиглалтын нөөцийн модуль л/с км^2	Газрын доорх хангамшлын нөхцөл
							Үндсэн төрөл	Усжилт	Уст үеийн зузаан, мм	Ус дамжуулах чадвар м/хон		
1000-1500	1.5-3.0	Хотгор kz-Q	155-200	5-10	30-50	Дунд	Q-kz-н ул хөрсний Mz-Kz-н үе	00.5-5.0	5-30	200-300	20-3	Сайн
1500-2000	3.0-6.0	Q-н элс хайрган хуримтлал	200-225	10-50	50-100 >100	Сайн	Q-н зузаан ул хөрсний	1-20.0	10-50	100-500	>3-4	Нэн сайн
2000-5000	6.0-12.0	Q-н хуримтлал, kz-өргөгдөл	225-250	50-100	20-50	Дунд	Q-н ба ан цавт ул хөрсний	0.5-10.0	1-10	50-100	2-3	Дунд
2500-3000	12.0-20.0	Kz-Mz өргөгдөл	250-300	100-200	20-10	Дунд	Q-н ба цавт ул хөрсний тектоник хагарал, судлын	0.1-5.0	2.5	20-50	0.5-1.0	Дунд юм уу муу
3000-4000	20.0	Pz-Mz-Kz өргөгдөл	300-400	200-300	<10	Муу	Ан цавт ул хөрсний тектоник хагарал судлын	0.1-3.0	1-5	5-20	05-аас бага	Маш муу



Зураг 20. Газрын доорх ус

БҮЛЭГ 9. ХӨРСӨН БҮРХЭВЧ

9.1.Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч

Асгат сум.

Тус сумын хөрсний хэв шинжийн хувьд Жинхэнэ хүрэн хөрс 661488.02 га, Нугын хужир /чийгт хэлбэрийн хужир/ хөрс 10051.79 га, Хар хүрэн хөрс 49323.56 га тус тус эзэлж байна. Асгат сумын нутагт зонхилон тархсан хөрсөн бүрхэвчийн онцлог:

Жинхэнэ хүрэн хөрс: Хуурай хээрийн бүсийн өмнөд хэсгээр, эсвэл хархүрэн хөрстэй талархаг нутгийн доторх уудам хотгоруудад харгана бүхий үетэнт, агь-үетэнт ургамалшилтай газраар тархах бөгөөд ургамал нөмрөгийн бүрхэц нь 30-50% байна. Хөрсний чийгийн хангамж төдий л сайн биш, зуны хамгийн их хур бороотой үед ус чийг хөрсөнд дөнгөж 20-40 см хүртэл нэвчдэг тул түүнээс доошох хэсэг нь хуурай голдуу байна. Хөрсний үе давхарга үүнээс гүн чийглэгдэх нь ховор. Хүрэн хөрс өвлийн улиралд 2.8-3.5 м хүртэл гүн хөлдөх авч -10°С- ын температур 60 см-ээс доош бараг нэвтэрдэггүй. Зуны цагт хөрс хүчтэй халж +10°С-температур 2 м хүртэл буюу түүнээс гүн нэвтэрдэг. Энэ бүгдээс харахад хүрэн хөрсний дулааны горим хархүрэн хөрснийхөөс их ялгаатай.

Хар хүрэн хөрс: Алаг өвс-үетэнт хуурай хээрийн ургамалшил дор тогтворжих бөгөөд өвслөг ургамлын бүрхэц газрын гадаргын 50-80%-ийг эзэлнэ. Өвлийн улиралд 3.4-4 м хүртэл гүн хөлдөж, - 10°С-ын температур хөрсөнд 80-90 см гүн нэвтэрнэ. Чийг багатай, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учраас улирлын цэвдэг нь мөсгүй байдаг онцлогтой. Дулааны улиралд хөрсний үе давхаргууд гайгүй сайн халж, ургамлын ургалтын хугацаанд + 10°С-ын температур хөрсөнд 160-170 см хүртэл гүн нэвтэрдэг.

Хархүрэн хөрсний ялзмаг хуримтлалын (А) давхаргын зузаан 280 зүсэлтийн дунджаар 23 см (хамгийн нимгэн нь 10-13 см, хамгийн зузаан нь 35-40 см) байх ба түүний доод хил зааг ямагт тод ялгарч харагдана. Ялзмаг хуримтлалын (А) давхарга, карбонатын давхарга (ВСа) хоёрын завсар ихэнх тохиолдолд (280-аас 215-д нь) бараавтар бор өнгөтэй, ялзмагжсан, дунджаар 15 см зузаан В, давхарга тогтсон байна.

Хархүрэн хөрсний дээд үе давхарга (0-10 см, 0-5 см) дахь ялзмагийн агууламж дунд ба хөнгөн шавранцар хөрсөнд 3-5%, элсэнцэр ба элсэн хөрсөнд 2-3% хүрч доошоо хурдан буурна.

Хархүрэн хөрсний биологийн идэвх харьцангуй өндөр. Хуурай уур амьсгалтай учраас бичил организмын бүрэлдэхүүнд бактери эрс давамгайлдаг. Хархүрэн хөрс агрохимийн шинжээр харьцангуй сайн, шим тэжээлийн элементийн агууламж хангалттай тул тус орны газар тариалангийн үндсэн эдэлбэр болж өгдөг. (Л.Доржготов, "Монгол орны хөрс", 2003 он)

Дарьганга сум.

Хөрсний хэв шинжийн хувьд Аллювийн нугын хөрс 685.25 га, Далд глейрхэг хар шороон хөрс 6596.64 га, Довцог элс 35273.30 га, Жинхэнэ хүрэн хөрс 199097.16 га, Нугын хужир /Чийгт хэлбэрийн хужир/ хөрс 9466.01 га, Нугын хүрэн хөрс 6729.17 га, Уулын хар хүрэн хөрс 4787.47 га, Уулын хүрэн хөрс 1334.67 га, Хар хүрэн хөрс 216859.36 га тус тус эзэлж байна.

Дарьганга сумын нутагт зонхилон тархсан хөрсөн бүрхэвчийн онцлог:

Жинхэнэ хүрэн хөрс: Хуурай хээрийн бүсийн өмнөд хэсгээр, эсвэл хархүрэн хөрстэй талархаг нутгийн доторх уудам хотгоруудад харгана бүхий үетэнт, агь-үетэнт 54 ургамалшилтай газраар тархах бөгөөд ургамал нөмрөгийн бүрхэц нь 30-50% байна. Хөрсний чийгийн хангамж төдий л сайн биш, зуны хамгийн их хур бороотой үед ус чийг хөрсөнд дөнгөж 20-40 см хүртэл нэвчдэг тул түүнээс доошох хэсэг нь хуурай голдуу байна. Хөрсний үе давхарга үүнээс гүн чийглэгдэх нь ховор. Хүрэн хөрс өвлийн улиралд 2.8-3.5 м хүртэл гүн хөлдөх авч -10°С- ын температур 60 см-ээс доош бараг нэвтэрдэггүй. Зуны цагт хөрс хүчтэй халж +10°С-температур 2 м хүртэл буюу түүнээс гүн нэвтэрдэг. Энэ бүгдээс харахад хүрэн хөрсний дулааны горим хархүрэн хөрснийхөөс их ялгаатай.

Уулын хүрэн хөрс: Улсын бүх нутгийн 6.3%-тай тэнцэх талбайг эзлэх бөгөөд хархүрэн хөрстэй харьцуулбал ялзмагийн агууламж багатай, ялзмаг хуримтлалын үе нь арай нимгэн, өнгөөр мэдэгдэхүйц гэгээтэй, карбонатын давхарга нэлээн дээр байдгаараа ялгаатай. Үе давхаргууд нь: А-(В)ВСа-ВССа-ССа гэсэн бүтэцтэй. Тод хүрэн өнгөтэй ялзмаг хуримтлалын давхарга нь дунджаар 14 см (хамгийн бага нь 6 см, хамгийн их нь 20 см) зузаан, 2-3% ялзмагтай. Түүний доорх В давхарга цөөн тохиолдолд илрэх бөгөөд ялзмаг багатай, метаморф шинж заримдаа ажиглагддаг, зузаан нь 14 см орчим байна. Ихэнх тохиолдолд А давхаргын доор карбонатын хуримтлалын (ВСа) давхарга шууд хиллэж оршино. Давсны хүчилд бургиж эхлэх гүн голдуу А давхаргын доороос8 В давхарга илэрсэн тохиолдолд А +В үеийн доороос, зарим цөөн тохиолдолд гадаргаасаа, эсвэл 70-80 см-ээс доош байна. Үүнээс үзэхэд ялзмаг хуримтлалын давхарга нь жирийн нөхцөлд карбонатгүй, солилцоот сууриудыг шингээх чадвар тааруухан (100 гр хөрсөнд 7-13 мг-экв) байна. Ширхгийн бүрэлдэхүүнээр хөнгөн шавранцар, элсэнцэр хөрс зонхилно. Урвалын орчин хөрсний дээд давхаргуудад саармаг буюу түүнтэй ойролцоо, доод давхаргуудад шүлтлэг шинжтэй. Уулын хүрэн хөрс байгалийн үржил шимээр хангалттай, дээд талын 0-20 см үе дэх ялзмагийн бодисын нөөц 50-70 т/га, бүх азотын хэмжээ 5-6 т/га орчим байна. Энэ хөрсөн дээрх өвслөг ургамлын бүрхэц 30-50% хүрнэ. Ийм хөрстэй бэлчээрийг жилийн дөрвөн улиралд сэлгэж ашиглах боломжтой.

Хар хүрэн хөрс: Алаг өвс-үетэнт хуурай хээрийн ургамалшил дор тогтворжих бөгөөд өвслөг ургамлын бүрхэц газрын гадаргын 50-80%-ийг эзэлнэ. Өвлийн улиралд 3.4-4 м хүртэл гүн хөлдөж, - 10°С-ын температур хөрсөнд 80-90 см гүн нэвтэрнэ. Чийг багатай, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учраас улирлын цэвдэг нь мөсгүй байдаг онцлогтой. Дулааны улиралд хөрсний үе давхаргууд гайгүй сайн халж, ургамлын ургалтын хугацаанд + 10°С-ын температур хөрсөнд 160-170 см хүртэл гүн нэвтэрдэг.

Хархүрэн хөрсний ялзмаг хуримтлалын (А) давхаргын зузаан 280 зүсэлтийн дунджаар 23 см (хамгийн нимгэн нь 10-13 см, хамгийн зузаан нь 35-40 см) байх ба түүний доод хил зааг ямагт тод ялгарч харагдана. Ялзмаг хуримтлалын (А) давхарга, карбонатын давхарга (ВСа) хоёрын завсар ихэнх тохиолдолд (280-аас 215-д нь) бараавтар бор өнгөтэй, ялзмагжсан, дунджаар 15 см зузаан В, давхарга тогтсон байна.

Хархүрэн хөрсний дээд үе давхарга (0-10 см, 0-5 см) дахь ялзмагийн агууламж дунд ба хөнгөн шавранцар хөрсөнд 3-5%, элсэнцэр ба элсэн хөрсөнд 2-3% хүрч доошооноо хурдан буурна.

Хархүрэн хөрсний биологийн идэвх харьцангуй өндөр. Хуурай уур амьсгалтай учраас бичил организмын бүрэлдэхүүнд бактери эрс давамгайлдаг. Хархүрэн хөрс

агрохимийн шинжээр харьцангуй сайн, шим тэжээлийн элементийн агууламж хангалттай тул тус орны газар тариалангийн үндсэн эдэлбэр болж өгдөг. (Л.Доржготов, 2003 он)

Судалгааны аргазүй: Хөрсөн бүрхэвчийн судалгааг дараах үе шаттай гүйцэтгэв

Бэлтгэл ажил: Төслийн талбайн байршлын 1:100 000-ын зургийг байр зүйн зурагт буулгаж хөрсний зүсэлт хийх, агрохимийн болон хүнд металлын дээж авах цэгүүдийг тэмдэглэн судалгааны эх зургийг бэлтгэсэн. Тухайн талбайтай холбоотой хөрсний судалгааны материалтай уншиж танилцсан.

Хээрийн судалгаа: Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн төлөв байдлыг тодорхойлох хээрийн судалгааг 2025 оны 07-р сарын 17-ны өдөр хийж гүйцэтгэв. Нийт 5 цэгт хөрсний зүсэлт хийж, агрохимийн 5 дээжийг 500-800 грамм хөрсний бохирдлыг тодорхойлох зорилгоор тус бүр авсан. Зүсэлт хийсэн цэгүүдийн газарзүйн байршлыг байршил тогтоогч GPS багажаар тэмдэглэсэн. Мөн хөрсний морфологи шинж чанарын бичиглэл хийсэн.

Лабораторийн задлан шинжилгээ: Хөрсний агрохимийн болон хүнд металлын дээжийг "Нарт консалтинг" ХХКомпанийн Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. Шинжилгээний дүнг хавсралтаар үзүүлэв.

Зураглалын судалгаа: Хөрсний судалгааны ажлын хамгийн чухал мэдээлэл нь хөрсний зураглалын судалгааны арга юм. Зураглалаар хөрсний бүрхэвч, хөрсний хил хязгаарын тархалт, элэгдэл эвдрэлийн байдал зэрэг чухал үзүүлэлтүүдийг хөрсний зургаар энгийн байдлаар харуулах боломжтой юм. Үүний тулд дээрх аргазүйн дагуу боловсруулсан, дүгнэсэн мэдээллүүддээ үндэслэн, мөн өмнөх суурь судалгааны материалуудыг ашиглан нэгж талбарын зургийг бэлтгэсэн.

Боловсруулалт: Хээрийн судалгааны ажлын үед хийсэн хөрсний морфологи шинж чанарын бичиглэл болон агрохимийн үзүүлэлтүүд, механик бүрэлдэхүүний лабораторийн шинжилгээний үр дүнг тус бүрээр үр дүнгийн хэсэгт үзүүлж, дэлгэрэнгүй тайлбар хийсэн. Хөрсний хүнд металлын лабораторийн шинжилгээний үр дүнг MNS 5850:2008 (Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ) стандарттай харьцуулан төслийн талбайн хөрсний хэв шинжийн зураг (1:100.000)-ийг хээрийн судалгааны үр дүн, Монгол улсын үндэсний атлас (2009)-ыг үндэслэн, ArcGIS 10.6.2 программ дээр боловсруулав.

Судалгааны үр дүн: Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд хар хүрэн хөрс болон уулын хар хүрэн хөрс тус тус тархсан байна.

Хүснэгт 17. Хөрсний морфологи бичиглэл 1

Хөрсний морфологи бичиглэл	
Хөрсний зүсэлтийн дугаар	Зүсэлт №1
Байршил	Сүхбаатар аймаг Асгат сум замын трасс эхлэл
Координат	46°02'31.22"N
	114°21'28.42"E
Огноо	2025.07.17
Өндөр	д.т.д 1054 метр
Газрын гадарга	Замын трассын эхлэл хэсэг

Хөрсний морфологи бичиглэл		
Ургамлын бүрхэвч		85-95%
Хөрсний нэр		Сайргархаг нимгэн хархүрэн ба ердийн хархүрэн хөрс
Хөрсний фото	**Гүн**	Морфологи бичиглэл
	0-20 см	Давхарга А0-20 (20)см, борхүрэн шороон тал хээрийн хүрэн хөрс, тоосорхог- бутрамтгай үрлэн бүтэцтэй, жижиг үйрмэг чулуу 10%-иас бага, элсэнцэр, хуурайвтар, нягт (1.29 г/см3), ургамлын үндсээр баялаг, давсны хүчилд бургихгүй, карбонат байхгүй, доош ухахад хад чулуу тохиолдож байна.

Хүснэгт 18. Хөрсний морфологи бичиглэл 2

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар		Зүсэлт №2
Байршил		Сүхбаатар аймаг Асгат сум замын трасс дунд хэсэг
Координат		45°56'58.81"N
		114°23'21.18"E
Огноо		2025.07.17
Өндөр		д.т.д 1089 метр
Газрын гадарга		Замын трассын төгсгөл хэсэг
Ургамлын бүрхэвч		80-90%
Хөрсний нэр		Ердийн хархүрэн ба сайргархаг хархүрэн хөрс
Хөрсний фото	**Гүн**	Морфологи бичиглэл
	0-20 см	Давхарга 0-20 (20)см, элсэн хүрэн өнгөтэй, тоосорхог-бутрамтгай үрлэн бүтэцтэй, жижиг үйрмэг чулуу (30-40%) бага, элсэнцэр, хуурай, нягт (1.25 г/см3), ургамлын үндсээр баялаг, давсны хүчилд бургихгүй, карбонат байхгүй, доош ухахад хад чулуутай, шилжилт өнгөөр тодорхой.

Хүснэгт 19. Хөрсний морфологи бичиглэл 3

Хөрсний морфологи бичиглэл	
Хөрсний зүсэлтийн дугаар	Зүсэлт №3
Байршил	Сүхбаатар аймаг Асгат сум замын трасс дунд хэсэг
Координат	45°46'8.98"N
	114°29'30.12"E
Огноо	2025.07.17
Өндөр	д.т.д 1401 метр
Газрын гадарга	Замын трассын дунд хэсэг
Ургамлын бүрхэвч	75-85%
Хөрсний нэр	Уулын нимгэн хархүрэн ба ердийн хархүрэн хөрс

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний фото	**Гүн**	Морфологи бичиглэл
	0-40 см	Давхарга 0-20 (20)см, хар хүрэн өнгөтэй, тоосорхог-бутрамтгай үрлэн бүтэцтэй, жижиг үйрмэг чулуу (20-30%) бага, элсэнцэр, хуурай, нягт (1.25 г/см3), ургамлын үндсээр баялаг, давсны хүчилд бургихгүй, карбонат байхгүй, доош ухахад хад чулуутай, шилжилт өнгөөр тодорхой.

Хүснэгт 20. Хөрсний морфологи бичиглэл 4

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар		Зүсэлт №4
Байршил		Сүхбаатар аймаг Асгат сум замын трасс дунд хэсэг
Координат		45°21'10.74"N
		114° 7'22.29"E
Огноо		2025.07.17
Өндөр		д.т.д 1350 метр
Газрын гадарга		Замын трассын дунд хэсэг
Ургамлын бүрхэвч		50-60%
Хөрсний нэр		Ердийн хархүрэн ба сайргархаг хархүрэн хөрс
Хөрсний фото	**Гүн**	Морфологи бичиглэл
	0-20 см	Давхарга 0-20 (20)см, хар хүрэн өнгөтэй, тоосорхог-бутрамтгай үрлэн бүтэцтэй, жижиг үйрмэг чулуу (20-30%) бага, элсэнцэр, хуурай, нягт (1.25 г/см3), ургамлын үндсээр баялаг, давсны хүчилд бургихгүй, карбонат байхгүй, доош ухахад хад чулуутай, шилжилт өнгөөр тодорхой.

Хүснэгт 21. Хөрсний морфологи бичиглэл 5

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар		Зүсэлт №5
Байршил		Сүхбаатар аймаг Асгат сум замын трасс төгсгөл
Координат		45°18'18.83"N
		113°52'34.97"E
Огноо		2025.07.17
Өндөр		д.т.д 1240 метр
Газрын гадарга		Замын трассын дунд хэсэг
Ургамлын бүрхэвч		75-85%
Хөрсний нэр		Нугын хужирлаг хөрс ба хужир
Хөрсний фото	**Гүн**	Морфологи бичиглэл

Хөрсний морфологи бичиглэл		
	0-20 см	Давхарга 0-20 (20)см Бор өнгөтэй, тоосорхог-бутрамтгай үрлэн бүтэцтэй, жижиг үйрмэг чулуу (20-30%) бага, элсэнцэр, хуурай, нягт (1.25 г/см3), ургамлын үндсээр баялаг, давсны хүчилд бургихгүй, карбонат байхгүй, доош ухахад хад чулуутай, шилжилт өнгөөр тодорхой.

Хөрсний агрохимийн үндсэн үзүүлэлтүүд

Хүснэгт 22. Хөрсний агрохимийн шинж чанар

Талбайн нэр	Гүн, см	pH	ЦДЧ, dS/m	Давс %	Ялзмаг, %	$CaCO_3$ %	NO_3 Мг/100г	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca	Mg	P_2O_5, мг-экв	K_2O мг-экв
Замын трассын эхлэл	0-20	99	0.035	0.015	1.65	0.48	0.08	12	7	0.5	12
Замын трассын дунд	0-20	8.84	0.036	0.015	2.09	0.00	0.08	14	6	1.9	7
	20-40	8.72	0.064	0.027	1.34	2.44	0.20	7	6	3.9	3
Замын трассын дунд	0-20	8.26	0.032	0.013	1.67	0.00	0.06	10	4	2.2	12
Замын трассын дунд	0-20	8.59	0.029	0.012	2.27	0.32	0.05	14	6	5.6	6
Замын трассын төгсгөл	0-20	8.47	0.028	0.012	1.59	0.00	0.05	8	3	3.4	8

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж их, карбонатгүй, шингээгдэх сууриудын нийлбэр хэмжээ дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар болон давсны агууламж маш бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хэмжээ бага, хөдөлгөөнт калийн хангамж дунд зэрэг байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хүснэгт 23. Хөрсний механик бүрэлдэхүүн

Талбайн нэр	Гүн, см	Механик ширхгүүд, % ширхгийн хэмжээ, мм						
		1-0,25	0,25-0,05	0,05-0,01	0,01-0,005	0,005-0,001	<0.001	<0.01
Замын трассын эхлэл	0-20	7.3	53.6	18.6	9.5	3.8	7.2	20.5
Замын трассын дунд	0-20	8.9	49.3	20.1	11.5	4.3	5.9	21.7
	20-40	4.6	47.0	24.6	12.4	3.2	8.2	23.8

Замын трассын дунд	0-20	7.6	62.6	11.4	9.2	3.6	5.6	18.4
Замын трассын дунд	0-20	6.9	60.6	15.3	7.2	5.3	4.7	17.2
Замын трассын төгсгөл	0-20	11.3	64.2	9.7	8.1	2.6	4.1	14.8



Зураг 21. Хөрсний хэв шинж

БҮЛЭГ 10. УРГАМЛАН НӨМРӨГ

10.1. Ургамлан нөмрөгийн байдал

Дарьганга сум.

Дарьганга сумын нийт нутаг дэвсгэрийн 74.8 хувийг тал хээрийн бэлчээрийн ургамал, 9.8 дундаж өндөр ба нам бэсрэг уул ургамлын бэлчээр, 7.1 хувийг говь цөлийн бэлчээрийн ургамал 5.9 хувийг бүс дундын голын хөндийн, гам хотосын бэлчээрийн ургамал тархсан байна.

Хүснэгт 24. Сумын ургамлын экологийн хэв шинж

№	Экологийн төрөл	Талбайн хэмжээ /га/	Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь
1	Нуур	2007.1	0.4
2	Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр	47340.5	9.8
3	Тал хээрийн бэлчээр	359426	74.8
4	Цөлөрхөг хээрийн бэлчээр	9596.1	2.0
5	Говь цөлийн бэлчээр	34186.3	7.1
6	Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр	28273	5.9
	нийт	480828.9	100



Зураг 22. Дарьганга сумын ургамлын экологийн хэв шинж, эзлэх хувиар

Монголын ургамлын аймаг нь бүр эртнээс, тухайлбал эртний төрмөлийн эрингийн чулуун нүүрс-пермийн галавын үеэс эх газар үүсэж улмаар Цэрдийн галавын үеэс эх газрын, хуурай уур амьсгал зонхилох болсон тэр цагаас үүсэж хөгжсөн гэж үздэг. Ялангуяа Неогений үеэс Гимлай, тэнгэр уул, Куньлуэнь, Их Хянган зэрэг өндөр уулсын систем эрчимтэй өргөгдөж сүндэрлэснээр Төв Азийн агаарын урсгал, хур тунадасны хуваарилагдах байдал өөрчлөгдөн хуурайшин цөлжих явцад ихээхэн нөлөөлсөн нь Төв Азийн цөлийн хээрийн ургамлыг аймгийг бүрдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэжээ.

Н. Өлзийхутаг (1976 он) Монголын ургамлын аймгийг 16 тойрогт хуваасан байдаг. Энэ мужлалаар Сүхбаатар аймгийг ургамлын 3 тойрогт хуваасан. Үүнд:

1. Дундад Халхын хээрийн тойрог

2. Дорнод Монголын хээрийн тойрог

3. Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог

Дундад Халхын хээрийн тойрог

Энэ тойрогт Баруун-Урт хотоос хойших нутаг хамрагдах ба энэ тойрог нь ургамлын аймгийн хувьд биеэ даасан өвөрмөц онцлог багатай, хэд хэдэн тойргийн шилжих зааг дээр байрлах учир Төв Азийн Монгол хошуу болоод Дагуурын хээрийн, зарим нь цөлөрхөг хээрийн бас умардын уулсын элементүүд оролцоно. Зөвхөн энэ тойрогт Taraxacum bessarabicum, Taraxacum Printzii гэсэн 2 зүйл тохиолдоно.

Дорнод Монголын хээрийн тойрог

Энэ тойрогт Баруун-Урт хотоос урагших нутаг хамрагдах ба умард зүгээс дагуурын, өмнө зүгээс Төв Азийн Монгол хошууны ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан нийлж буй шилжилтийн бүс таардаг байна. Бас Дорноос Манжуурын элементүүд цөөнгүй үзэгдэнэ. Тухайн тойрогт тохиолддог зүйл 17 байна. Жишээ нь: Литвиновын ботууль, Урт дохиурт сонгино, Потанины сараана, Цуулбарнавчит зогдор, өвс, Валерийн тарна, Грубовын бэрмэг, Үст дэлбээт бүрзэг, Урт навчит далан товч, Манж сүүт өвс, Тал нүцгэн гичгэнэ, Бамбай, түмэнтана, Сэгсгэр хошоон бут, Наалданхай гүүн хөх, Өргөний зохимон, Саваан лууль зэрэг өвөрмөц төлөөлөгчидтэй.

Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог

Энэ тойрогт тус аймгийн Дорноговь аймагтай хиллэх баруун урд багахан хэсэг хамрагдах бөгөөд энэ тойрог нь жинхэнэ говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн ургамлын аймагтай. Зөвхөн тухайн тойрогт тохиолдох 6 зүйл байгаагийн жишээ нь Говийн бэрмэг, Боргоцой хамхуул, Хатгуурт сэдэргэнэ, Зөөлөвтөр лавай, Монгол шарилж, Арзгар ишт сульхиаг болно.

Ургамалшлын тархалтад голлон нөлөөлөх хүчин зүйл нь газар нутгийн хэмжээ, хотгор гүдгэр 2 юм. Манай улсын нутаг дэвсгэр хойноосоо урагшаа 1200 гаруй км үргэлжилсэн тул тэр чиглэлд өргөргийн хэд хэдэн бүс дараалан оршино. Гэвч хойд хэсэг гол төлөв уулсаар эзлэгдсэн тул бүсүүдийн байршилтыг ямар нэг хэмжээгээр ээдрээтэй болгож, босоо бүслүүрийг үүсгэнэ. Харин уулс ихэвчлэн хойд хэсэгт өндөр, урд хэсгээр нам учир босоо бүслүүрүүд хойд талын нутгаар тод, урд талын нутгаар тодорхой гарч чаддаггүй. Монгол орны газрын гадаргын онцлогтой холбоотой ургамалжилтын 6 бүс, бүслүүртэй бөгөөд тус аймагт хээрийн ба цөлөрхөг хээрийн бүсийн ургамал тархана.

Харин ГЗБГЗЗГ-аас гаргасан "Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, үр дүнг хүлээн авах журам"-д "Монгол орны бэлчээр хадлангийн ангилаа"-гаар нийт 9-бүсэд хуваан ангилсан байдаг. Үүнд:

Ө- Өндөр уулын бэлчээр

У- Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр

ӨХ- Өндөр уулын хоорондох нуга хөндий

УХ- Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий

Х- Тал хээрийн бэлчээр

ЦХ- Цөлөрхөг хээрийн бэлчээр

Ц- Говь цөлийн бэлчээр

Н - Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр

БТ- Бэлчээрт тохиромжгүй газар

Эдгээрээс Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр /У/, Тал хээрийн бэлчээр /Х/, Цөлөрхөг хээрийн бэлчээр /ЦХ/, Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр /Н/, Бэлчээрт тохиромжгүй газар /БТ/ гэсэн бүсүүд байна.

Тал хээрийн бүс

Монголын хээр нь Европ дахь Мажар улсын Дунайн "пушт" хэмээх хээрээс Дорнод Ази дахь Манжуурын хээр хүртэлх хээрийн дорнод хэсэгт нь оршдог юм. Хээрийн ургамалжилт зонхилж хатуу, хуурайсаг үетнээс бүрдэх боловч Монголын хээрийн бусдаас ялгагдах нэг онцлог нь хуурайсаг сөөг болох хэд хэдэн зүйл Харгана, Агь (хүйтсэг Шарилж) зэрэг сөөг сөөгөнцөр ихтэй явдал юм.

Хээрийн бүсэд үржил шим сайтай хар хүрэн, заримдаа элсэнцэр хүрэн хөрстэй. Хээрийн бүс нь Дорнод Монгол, Дундад халхын тэгш өндөрлөг, өргөн уудам тал газрыг хамарч баруун тийш нарийссаар Хангайн нурууны өврийн нам уулсын бэлээр дамжин Хан-Хөхийн өмнөд бэл хүртэл нарийн зурвас газраар Их нууруудын хотгорт хүрч замхарна.

Монголын хээрт Хялгана-Хазаар өвст, Хиаг-Хялганат, Хиаг-Өлөн-Агьт, Хялгана-Хазаар өвс-Агьт, Хялгана-Агьт, Хиаг –элдэв өвст, Шивээт хялгана-Монгол өвст, Хялгана-Таанат, Дэгнүүлт дөрвөн үетэнт, Зүр өвст, Элдэв өвст-үетэнт, Харганат хээр зонхилно. Хээрийн бүсийн дээр дурдсан эвшлүүдийг бүрэлдүүлэгч ургамал нь өдлөг Хялгана, (Монгол өвс) Байгал Хялгана, Крыловын Хялгана,том Хялгана, дэрвээн Хазаар өвс, Саман Ерхөг, хиаглан Түнгэ, Нангиад Хиаг, туяхан дурваа, туужууны биелэг, зэрэг үетэн; ширэг, Улалж, зогдор өлөн зэрэг өлөн; Хүтсэг Шарилж, Адамсын шарилж, маралхин Шарилж, хөх ногоон Шарилж, Ишгэн Шарилж, ишгүй Гичгэнэ, маралнавчит Гичгэнэ, имт Гичгэнэ, Сибирь Зүр өвс, Дагуур Хатны өвс, Турчаниновын Яргуй, Бунгийн яргуй, хоёр ишт Бэриш, арзгар Согсоолж, Хонгорзул, Амманы Сэдэргэнэ (Бор элгэнэ), юлдэн Тарваган шийр, хоншоохой Аунчир, орос Чирэг, нарийн сонгино, Гогод, Мангир, үхэр Тарна, Дагуурын Тайжинс, алаг Башир, жинхэнэ Өрөмтүүл, Байгал Маалинга, Дагуур Бортайр, шаралдуу Уул-өвс, Дагуур Хуж өвс, Дагуур Хэрээний нүд, цомогт Бэрцэцэг, буурал Янгиц, буурал Гандбадраа, шар Хумхаал, тарваган Далан түрүү, намхан Сараана, дэрвээн Буржгар, говийн Ганга, бүхэл навчит Багдай элдэв өвс болно.

Хээрт хамгийн түгээмэл хэвшил нь өнгөн үедээ нэлээд элсэрхэг юм уу хайргархаг хөрстэй нутагт тохиолдох харганат хээр юм. Харганат хээр нь Хялганат ба хялгана-хазаар өвст хээрээс зүйлийн бүрдлээрээ онцын ялгаагүй бөгөөд гол төлөв Дундад Халхад түгээмэл тархжээ. Хялганат хээрийн олон хувилбар болох Зүр өвст хээр, Дэгнүүлт дөрвөн үетэнт хээр, Шивээт ба өдлөг Хялганат хээр, Хялгана-Таанат хээр нь тус аймагт бий. Жижиг толгод, нам уулсын хажуу, энгэр дагаж чулуурхаг, хайргархаг хээрийн хувилбар байх ба энд хээрийн бусад хэв шинжээс зүйлийн бүрдлээрээ ялгагдах зүйл үгүй, харин харьцангуйгаар нэлээд чийгсэг, нам хөндийд ургадаг Хиаг, хиаглай Түнгэ, зарим зүйлийн элдэв өвс алга болдог. Уул, толгодын эгц хажуу, энгэр, жалга дагаж бариулт Бүйлэс, улаан

Харгана, Сөөгөн Эмгэншилбэ, Тэхийн шээг, Монгол Догор, орог Тэсэг, дэлхээ Тогторгоно, Цагаан Ортууз, зэрэг сөөг сөөгөнцөр ургана. Уулархаг газруудаараа Хялганат, Хялгана-алаг өвст, Хялгана-хиагт, Хялгана-үетэнт, Хялгана-хазаарт, Хялгана-харганат Жижиг дэгнүүл үетэн-алаг өвст, Үетэн-алаг өвст, Хазаар-хялганат, Хазаар өвс-үетэнт зэрэг бэлчээр тархсан байна. Уулын хээрээр Хиагт, Хиаг-алаг өвст, Хиаг-дэрст, Хялгана-жижиг дэгнүүл-үетэнт, Хялгана-хиагт , Хялгана-хазаарт, Хялганат, Хялгана-алаг өвст, Жижиг дэгнүүлт үетэн , Жижиг дэгнүүлт үетэн-хялганат, Алаг өвс-үетэнт, Хялгана-харганат, Үетэн-алаг өвст, Хазаар-жижиг дэгнүүл үетэнт, Хазаар өвс-хялганат бэлчээрийн төрлүүд зонхилж байна.

Голын хөндий, нам хотосоор Үетэн-цахилдаг-алаг өвст, Дэрс-хиаг-алаг өвст, Дэрс-өлөнгөт, Дэрс-алаг өвст (таанатай) бэлчээрийн төрлүүд нь голын нам хотосын хужир мараат нугад ихэвчлэн тархсан байна.

Тал хөндийн бэлчээрт Шивээт хялгана, Хиаг, Гашуун агь, Саман ерхөг, Эмт гичгэнэ, Хурган чих, Шувуун хөл, Нарийн харгана, Үхэр харгана, Гоо юлд, Нарийн бэрмэг, Хонгор зул, Дааган сүүл гэх мэт ургамал.

Нам хотос газруудын хужир мараалаг хөрстэй бэлчээрт Дэрс, Хиаг, Биелэг, Улаан толгой, Нугын дурвалаг, Ширэг улалж, Бясаат улалж, Бут улалж, Намгийн гурвалж, Галуун гичгэнэ, Таван салаа, Багваахай, Сорвоо, Үхэр харгана, Бор шар бударгана, Хэрс зэрэг ургамлууд зонхилсон байна.

Нам уулын бэлчээрт Ленийн ботууль, Туужууны биелэг, Шивээт хялгана, Мөлхөө ганга, Марал навчит гичгэнэ, Хоёр гэрт бэрж, Бэр цэцэг, Ягаан ганга, Саман ерхөг, Шувуун хөл, Орос чирэг, Ортууз, Хунчир, Нарийн ба үхэр харгана, Хонгор зул, Гол гэсэр, Хүж өвс зэрэг зонхилох ба Шивээт хялгана зарим газартаа 70-80 см бусад үетэн алаг өвс 20-50см өндөртэй.

Цөлөрхөг хээрийн бүс

Энэ бүсэд Сүхбаатар аймгийн урд багахан хэсэг хамрагдах бөгөөд энэ нь Монголын хээр, Төв Азийн цөлийн зааг дээр нэлээд эрт үүсэж бий болсон, зөвхөн энэ бүсдээ ургадаг зонхилогч ургамлуудтай байдгаараа онцлог бөгөөд цөлөрхөг хээрт амьдралын хэлбэрийн хувьд хуурайсаг сөөгөнцрүүд нэлээд оролцож, дэгнүүлт жижиг үетэн зонхилдог. Энд уул толгодын бэл, уулс хоорондын өргөн хөндий, ухаа гүвээний бор хөрсөнд Монгол өвст (өдлөг хялгана) цөлөрхөг хээр түгээмэл тааралддаг. Энд өдлөг Хялганын бүлэгт хамаарах Говийн хялгана, Сайрын хялгана, (эдгээрийг Монгол өвс гэдэг), Дорнодын хялгана, Кавказын хялгана мөн Нангиад Хазаар өвс зонхилохоос гадна Таана, Агь, Цагаан шаваг, Бор шаваг, Боролзой оролцоно. Дэлхээ, Догторгоно, навчгүй Баглуур, буурал Янгиц, Бор Элгэнэ, өргөст Ортууз, орог Тэсэг, нэлээд тохиолдохоос гадна хур бороо ихтэй зун ямаан Шарилж, Шүлхий Шарилж их ургадаг. Энд Могол өвс-Боролзойт хээр, Могол өвс-Таанат цөл, Монгол өвс-Таана-Бударгана, Монгол өвс-бударагнат, Харгана-монгол өвст, Тэсэг-Монгол өвст, Хотир-Монгол өвст, Шаваг-Монгол өвст, Бор бударганат, Бор бударгана-хойрогт, Баглуурт, сөөгт цөлөрхөг хээр их тааралдана. Цөлөрхөг хээр жижиг үетнүүдээс гадна гуравласан Боролзой, төлөгчдүү Боролзой, Таана, орог Тэсэг, Бор бударгана, навчгүй Баглуур, Нохой Шээрэн, улаан Харгана, Бунгийн (бор) Харгана, шивүүрт Харгана, Цулбуур өвс, Хойрог, говийн Тост, Хамхуул, Хамхаг ургана. Энд бас Булгансүүл, Оготнынсүүл, Хургалж, Нохойн бөөдий зэрэг нэг наст үетэн, хамхаг, хамхуул, будан, Хамхаг, зарим шарилж хуртай зун их ургаж өтгөн сахлаг ургацтай болно. Марц, хужиртай тойромд Улаан бударгана, Шар бударгана, Цагаан мод, түүний хүрээг дагаж Хармаг их ургаж товцог

үүсгэнэ. Элсэрхэг хөндий, манхан дагаж Шар Шаваг, Хар суль, Элсний Цултхир, цагаан суль, монгол Торлог, Цулбуур өвс, сайр садарга дагаж Нангиад Хазаар өвс, сайрын Хялгана, хад чулуурхаг хажууг дагаж Пеллиотын Шивэлз, сөөгөн Боролзой, Төвд Заан таваг, Монгол Чоногоно, Монгол Догар, Морин зээргэнэ, данхар Хависхана ургадаг. (ГЗБГЗЗГ, 2020 он)

Асгат сум.

Монголын ургамлын аймаг нь бүр эртнээс, тухайлбал эртний төрмөлийн эрингийн чулуун нүүрс-пермийн галавын үеэс эх газар үүсэж улмаар Цэрдийн галавын үеэс эх газрын, хуурай уур амьсгал зонхилох болсон тэр цагаас үүсэж хөгжсөн гэж үздэг. Ялангуяа Неогений үеэс Гимлай, тэнгэр уул, Куньлуэнь, Их Хянган зэрэг өндөр уулсын систем эрчимтэй өргөгдөж сүндэрлэснээр Төв Азийн агаарын урсгал, хур тунадасны хуваарилагдах байдал өөрчлөгдөн хуурайшин цөлжих явцад ихээхэн нөлөөлсөн нь Төв Азийн цөлийн хээрийн ургамлыг аймгийг бүрдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэжээ.

Н. Өлзийхутаг (1976 он) Монголын ургамлын аймгийг 16 тойрогт хуваасан байдаг. Энэ мужлалаар Сүхбаатар аймгийг ургамлын 3 тойрогт хуваасан. Үүнд:

1. Дундад Халхын хээрийн тойрог
2. Дорнод Монголын хээрийн тойрог
3. Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог

Дундад Халхын хээрийн тойрог

Энэ тойрогт Баруун-Урт хотоос хойших нутаг хамрагдах ба энэ тойрог нь ургамлын аймгийн хувьд биеэ даасан өвөрмөц онцлог багатай, хэд хэдэн тойргийн шилжих зааг дээр байрлах учир Төв Азийн Монгол хошуу болоод Дагуурын хээрийн, зарим нь цөлөрхөг хээрийн бас умардын уулсын элементүүд оролцоно. Зөвхөн энэ тойрогт Taraxacum bessarabicum, Taraxacum Printzii гэсэн 2 зүйл тохиолдоно.

Дорнод Монголын хээрийн тойрог

Энэ тойрогт Баруун-Урт хотоос урагших нутаг хамрагдах ба умард зүгээс дагуурын, өмнө зүгээс Төв Азийн Монгол хошууны ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан нийлж буй шилжилтийн бүс таардаг байна. Бас Дорноос Манжуурын элементүүд цөөнгүй үзэгдэнэ. Тухайн тойрогт тохиолддог зүйл 17 байна. Жишээ нь: Литвиновын ботууль, Урт дохиурт сонгино, Потанины сараана, Цуулбарнавчит зогдор, өвс, Валерийн тарна, Грубовын бэрмэг, Үст дэлбээт бүрзэг, Урт навчит далан товч, Манж сүүт өвс, Тал нүцгэн гичгэнэ, Бамбай, түмэнтана, Сэгсгэр хошоон бут, Наалданхай гүүн хөх, Өргөний зохимон, Саваан лууль зэрэг өвөрмөц төлөөлөгчидтэй.

Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог

Энэ тойрогт тус аймгийн Дорноговь аймагтай хиллэх баруун урд багахан хэсэг хамрагдах бөгөөд энэ тойрог нь жинхэнэ говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн ургамлын аймагтай. Зөвхөн тухайн тойрогт тохиолдох 6 зүйл байгаагийн жишээ нь Говийн бэрмэг, Боргоцой хамхуул, Хатгуурт сэдэргэнэ, Зөөлөвтөр лавай, Монгол шарилж, Арзгар ишт сульхиаг болно.

Ургамалшлын тархалтад голлон нөлөөлөх хүчин зүйл нь газар нутгийн хэмжээ, хотгор гүдгэр 2 юм. Манай улсын нутаг дэвсгэр хойноосоо урагшаа 1200 гаруй км үргэлжилсэн тул тэр чиглэлд өргөргийн хэд хэдэн бүс дараалан оршино. Гэвч хойд хэсэг

гол төлөв уулсаар эзлэгдсэн тул бүсүүдийн байршилтыг ямар нэг хэмжээгээр ээдрээтэй болгож, босоо бүслүүрийг үүсгэнэ. Харин уулс ихэвчлэн хойд хэсэгт өндөр, урд хэсгээр нам учир босоо бүслүүрүүд хойд талын нутгаар тод, урд талын нутгаар тодорхой гарч чаддаггүй. Монгол орны газрын гадаргын онцлогтой холбоотой ургамалжилтын 6 бүс, бүслүүртэй бөгөөд тус аймагт хээрийн ба цөлөрхөг хээрийн бүсийн ургамал тархана.

Харин ГЗБГЗЗГ-аас гаргасан "Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, үр дүнг хүлээн авах журам"-д "Монгол орны бэлчээр хадлангийн ангилаа"-гаар нийт 9-бүсэд хуваан ангилсан байдаг. Үүнд:

Ө- Өндөр уулын бэлчээр

У- Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр

ӨХ- Өндөр уулын хоорондох нуга хөндий

УХ- Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий

Х- Тал хээрийн бэлчээр

ЦХ- Цөлөрхөг хээрийн бэлчээр

Ц- Говь цөлийн бэлчээр

Н - Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр

БТ- Бэлчээрт тохиромжгүй газар

Эдгээрээс Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр /У/, Тал хээрийн бэлчээр /Х/, Цөлөрхөг хээрийн бэлчээр /ЦХ/, Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр /Н/, Бэлчээрт тохиромжгүй газар /БТ/ гэсэн бүсүүд байна.

Тал хээрийн бүс

Монголын хээр нь Европ дахь Мажар улсын Дунайн "пушт" хэмээх хээрээс Дорнод Ази дахь Манжуурын хээр хүртэлх хээрийн дорнод хэсэгт нь оршдог юм. Хээрийн ургамалжилт зонхилж хатуу, хуурайсаг үетнээс бүрдэх боловч Монголын хээрийн бусдаас ялгагдах нэг онцлог нь хуурайсаг сөөг болох хэд хэдэн зүйл Харгана, Агь (хүйтсэг Шарилж) зэрэг сөөг сөөгөнцөр ихтэй явдал юм.

Хээрийн бүсэд үржил шим сайтай хар хүрэн, заримдаа элсэнцэр хүрэн хөрстэй. Хээрийн бүс нь Дорнод Монгол, Дундад халхын тэгш өндөрлөг, өргөн уудам тал газрыг хамарч баруун тийш нарийссаар Хангайн нурууны өврийн нам уулсын бэлээр дамжин Хан-Хөхийн өмнөд бэл хүртэл нарийн зурвас газраар Их нууруудын хотгорт хүрч замхарна.

Монголын хээрт Хялгана-Хазаар өвст, Хиаг-Хялганат, Хиаг-Өлөн-Агьт, Хялгана-Хазаар өвс-Агьт, Хялгана-Агьт, Хиаг –элдэв өвст, Шивээт хялгана-Монгол өвст, Хялгана-Таанат, Дэгнүүлт дөрвөн үетэнт, Зүр өвст, Элдэв өвст-үетэнт, Харганат хээр зонхилно. Хээрийн бүсийн дээр дурдсан эвшлүүдийг бүрэлдүүлэгч ургамал нь өдлөг Хялгана, (Монгол өвс) Байгал Хялгана, Крыловын Хялгана,том Хялгана, дэрвээн Хазаар өвс, Саман Ерхөг, хиаглан Түнгэ, Нангиад Хиаг, туяхан дурваа, туужууны биелэг, зэрэг үетэн; ширэг, Улалж, зогдор өлөн зэрэг өлөн; Хүтсэг Шарилж, Адамсын шарилж, маралхин Шарилж, хөх ногоон Шарилж, Ишгэн Шарилж, ишгүй Гичгэнэ, маралнавчит Гичгэнэ, имт Гичгэнэ, Сибирь Зүр өвс, Дагуур Хатны өвс, Турчаниновын Яргуй, Бунгийн яргуй, хоёр ишт Бэриш,

арзгар Согсоолж, Хонгорзул, Амманы Сэдэргэнэ (Бор элгэнэ), юлдэн Тарваган шийр, хоншоохой Аунчир, орос Чирэг, нарийн сонгино, Гогод, Мангир, үхэр Тарна, Дагуурын Тайжинс, алаг Башир, жинхэнэ Өрөмтүүл, Байгал Маалинга, Дагуур Бортайр, шаралдуу Уул-өвс, Дагуур Хуж өвс, Дагуур Хэрээний нүд, цомогт Бэрцэцэг, буурал Янгиц, буурал Гандбадраа, шар Хумхаал, тарваган Далан түрүү, намхан Сараана, дэрвээн Буржгар, говийн Ганга, бүхэл навчит Багдай элдэв өвс болно.

Хээрт хамгийн түгээмэл хэвшил нь өнгөн үедээ нэлээд элсэрхэг юм уу хайргархаг хөрстэй нутагт тохиолдох харганат хээр юм. Харганат хээр нь Хялганат ба хялгана-хазаар өвст хээрээс зүйлийн бүрдлээрээ онцын ялгаагүй бөгөөд гол төлөв Дундад Халхад түгээмэл тархжээ. Хялганат хээрийн олон хувилбар болох Зүр өвст хээр, Дэгнүүлт дөрвөн үетэнт хээр, Шивээт ба өдлөг Хялганат хээр, Хялгана-Таанат хээр нь тус аймагт бий. Жижиг толгод, нам уулсын хажуу, энгэр дагаж чулуурхаг, хайргархаг хээрийн хувилбар байх ба энд хээрийн бусад хэв шинжээс зүйлийн бүрдлээрээ ялгагдах зүйл үгүй, харин харьцангуйгаар нэлээд чийгсэг, нам хөндийд ургадаг Хиаг, хиаглай Түнгэ, зарим зүйлийн элдэв өвс алга болдог. Уул, толгодын эгц хажуу, энгэр, жалга дагаж бариулт Бүйлэс, улаан Харгана, Сөөгөн Эмгэншилбэ, Тэхийн шээг, Монгол Догор, орог Тэсэг, дэлхээ Тогторгоно, Цагаан Ортууз, зэрэг сөөг сөөгөнцөр ургана. Уулархаг газруудаараа Хялганат, Хялгана-алаг өвст, Хялгана-хиагт, Хялгана-үетэнт, Хялгана-хазаарт, Хялгана-харганат Жижиг дэгнүүл үетэн-алаг өвст, Үетэн-алаг өвст, Хазаар-хялганат, Хазаар өвс-үетэнт зэрэг бэлчээр тархсан байна. Уулын хээрээр Хиагт, Хиаг-алаг өвст, Хиаг-дэрст, Хялгана-жижиг дэгнүүл-үетэнт, Хялгана-хиагт , Хялгана-хазаарт, Хялганат, Хялгана-алаг өвст, Жижиг дэгнүүлт үетэн , Жижиг дэгнүүлт үетэн-хялганат, Алаг өвс-үетэнт, Хялгана-харганат, Үетэн-алаг өвст, Хазаар-жижиг дэгнүүл үетэнт, Хазаар өвс-хялганат бэлчээрийн төрлүүд зонхилж байна.

Голын хөндий, нам хотосоор Үетэн-цахилдаг-алаг өвст, Дэрс-хиаг-алаг өвст, Дэрс-өлөнгөт, Дэрс-алаг өвст (таанатай) бэлчээрийн төрлүүд нь голын нам хотосын хужир мараат нугад ихэвчлэн тархсан байна.

Тал хөндийн бэлчээрт Шивээт хялгана, Хиаг, Гашуун агь, Саман ерхөг, Эмт гичгэнэ, Хурган чих, Шувуун хөл, Нарийн харгана, Үхэр харгана, Гоо юлд, Нарийн бэрмэг, Хонгор зул, Дааган сүүл гэх мэт ургамал.

Нам хотос газруудын хужир мараалаг хөрстэй бэлчээрт Дэрс, Хиаг, Биелэг, Улаан толгой, Нугын дурвалаг, Ширэг улалж, Бясаат улалж, Бут улалж, Намгийн гурвалж, Галуун гичгэнэ, Таван салаа, Багваахай, Сорвоо, Үхэр харгана, Бор шар бударгана, Хэрс зэрэг ургамлууд зонхилсон байна.

Нам уулын бэлчээрт Ленийн ботууль, Туужууны биелэг, Шивээт хялгана, Мөлхөө ганга, Марал навчит гичгэнэ, Хоёр гэрт бэрж, Бэр цэцэг, Ягаан ганга, Саман ерхөг, Шувуун хөл, Орос чирэг, Ортууз, Хунчир, Нарийн ба үхэр харгана, Хонгор зул, Гол гэсэр, Хүж өвс зэрэг зонхилох ба Шивээт хялгана зарим газартаа 70-80 см бусад үетэн алаг өвс 20-50см өндөртэй.

Цөлөрхөг хээрийн бүс

Энэ бүсэд Сүхбаатар аймгийн урд багахан хэсэг хамрагдах бөгөөд энэ нь Монголын хээр, Төв Азийн цөлийн зааг дээр нэлээд эрт үүсэж бий болсон, зөвхөн энэ бүсдээ ургадаг зонхилогч ургамлуудтай байдгаараа онцлог бөгөөд цөлөрхөг хээрт амьдралын хэлбэрийн хувьд хуурайсаг сөөгөнцрүүд нэлээд оролцож, дэгнүүлт жижиг үетэн зонхилдог. Энд уул

толгодын бэл, уулс хоорондын өргөн хөндий, ухаа гүвээний бор хөрсөнд Монгол өвст (өдлөг хялгана) цөлөрхөг хээр түгээмэл тааралддаг. Энд өдлөг Хялганын бүлэгт хамаарах Говийн хялгана, Сайрын хялгана, (эдгээрийг Монгол өвс гэдэг), Дорнодын хялгана, Кавказын хялгана мөн Нангиад Хазаар өвс зонхилохоос гадна Таана, Агь, Цагаан шаваг, Бор шаваг, Боролзой оролцоно. Дэлхээ, Догторгоно, навчгүй Баглуур, буурал Янгиц, Бор Элгэнэ, өргөст Ортууз, орог Тэсэг, нэлээд тохиолдохоос гадна хур бороо ихтэй зун ямаан Шарилж, Шүлхий Шарилж их ургадаг. Энд Могол өвс-Боролзойт хээр, Могол өвс-Таанат цөл, Монгол өвс-Таана-Бударгана, Монгол өвс-бударагнат, Харгана-монгол өвст, Тэсэг-Монгол өвст, Хотир-Монгол өвст, Шаваг-Монгол өвст, Бор бударганат, Бор бударгана-хойрогт, Баглуурт, сөөгт цөлөрхөг хээр их тааралдана. Цөлөрхөг хээр жижиг үетнүүдээс гадна гуравласан Боролзой, төлөгчдүү Боролзой, Таана, орог Тэсэг, Бор бударгана, навчгүй Баглуур, Нохой Шээрэн, улаан Харгана, Бунгийн (бор) Харгана, шивүүрт Харгана, Цулбуур өвс, Хойрог, говийн Тост, Хамхуул, Хамхаг ургана. Энд бас Булгансүүл, Оготнынсүүл, Хургалж, Нохойн бөөдий зэрэг нэг наст үетэн, хамхаг, хамхуул, будан, Хамхаг, зарим шарилж хуртай зун их ургаж өтгөн сахлаг ургацтай болно. Марц, хужиртай тойромд Улаан бударгана, Шар бударгана, Цагаан мод, түүний хүрээг дагаж Хармаг их ургаж товцог үүсгэнэ. Элсэрхэг хөндий, манхан дагаж Шар Шаваг, Хар суль, Элсний Цултхир, цагаан суль, монгол Торлог, Цулбуур өвс, сайр садарга дагаж Нангиад Хазаар өвс, сайрын Хялгана, хад чулуурхаг хажууг дагаж Пеллиотын Шивэлз, сөөгөн Боролзой, Төвд Заан таваг, Монгол Чоногоно, Монгол Догар, Морин зээргэнэ, данхар Хависхана ургадаг. (ГЗБГЗЗГ, 2020 он)

10.2. Ургамлан нөмрөгийн өнөөгийн байдал

Талбайн байршил: Сүхбаатар аймаг,Асгат сум,
Огноо: 2025-07-17
Бичиглэл цэгийн байршил: Замын трассын дагуу
Бичиглэл хийсэн цэгийн өндөр /м/: 1054 м
Газрын гадарга: Тэгшивтэр **Гадаргын налуу:** 0-5 градус
Гадаргын чулуу: Бага **Чулууны бүрхэц:** 0-10 %
Ургамлын бүлгэмдлийн нэр: Хялгана-хиагт /Х-1-2-4/
Ургамал бүрхэц: 80-90 %
Ургамлын өндөр: 0-6 см
Ургамлан нөмрөгийн талхагдал: бага зэрэг талхлагдсан.

Зураг 23. Төслийн талбай дахь ургамал

Зураг 24. Ургамалын бичиглэл



Зураг 25. Ургамлан нөмрөг

БҮЛЭГ 11. АМЬТНЫ АЙМАГ

11.1. Амьтны аймаг

Дарьганга сум

Дарьганга сумын хувьд усны шувууд ихээр цугладаг бөгөөд Шилийн богд, Молцог элс орчмоор нэн ховор болон ховор ан амьтан ихээхэн тарсан бөгөөд аргаль хонь, бор гөрөөс, бор туулай, дагуур зурам, мануул, монгол тарвага, саарал чоно, хярс, шар үнэг, илбэнхи тархсан байна.



Зураг 26. Амьтны тархалтын нөөцийн зураг

Асгат сум

Дундад Халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн муж: Энэ мужид нийтдээ 6 ангийн 343 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 52.7% нь оршин амьдардаг байна. Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амьтан	Бүгд
Баг	5	17	1	1	7	1	32
Овог	17	44	4	3	11	1	80
Зүйл	63 /45.3%/	219 /52.7%/	8 /38.1%/	3 /50%/	49 /71%/	1 /100%/	343 /52.7%/

/*Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтад бичив./

/Эх үүсвэр: УГЗБЕТ, 2018 он/

Дорнод Монголын цав толгодорхог нам уулс бүхий хээрийн муж: Энэ мужид нийтдээ 4 ангийн 127 зүйл буюу манай орны сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүний 19.5 % нь оршин амьдардаг байна.

Хүснэгт 25. Дорнод Монголын цав толгодорхог нам уулс бүхий хээрийн мужийн сээр нуруутан амьтдын зүйлийн бүрэлдэхүүн

Нэгж	Дэлэнтэн	Шувуу	Мөлхөгчид	Хоёр нутагтан	Загас	Дугариг амьтан	Бүгд
Баг	4	15	1	1	-	-	21
Овог	12	27	4	2	-	-	45
Зүйл	31 /22.3%/	88 /21.2%/	6 /28.5%/	2 /33.3%/	-	-	127 /19.5%/

/*Тайлбар: Монгол оронд бүртгэгдсэн тухайн ангийн амьтдын зүйлийн бүрэлдэхүүний хэдэн хувийг эзэлж буйг хаалтад бичив./

/Эх үүсвэр: УГЗБЕТ, 2018 он/

БҮЛЭГ 12. ТҮҮХ СОЁЛЫН ӨВ

Дарьганга сум:

Нутгийн тал хувийг эзлэн оршдог Дарьгангын нутгийн ард түмний зан заншил, түүх соёл нь аймагтаа төдийгүй улсдаа онцгой байр эзэлдэг. Дарьгангачууд үе дамжсан сүлжих, ширэх, нэхэх, хатгах, зүү ороох зэрэг урлалыг чадмаг хийдгийн дээр дархан хүний уран ухааныг шингээн мөнгөөр сийлж, цоолж, ухаж, хөөж хийдэг дахин давтагдашгүй бүтээлээрээ алдартай. Монгол орны эртний түүхийн гайхамшигт бүтээл дурсгал болох чамин тансаг хийц бүхий 13-17-р зууны үеийн хүн чулуун хөрөг хөшөө 50 гаруй байдаг бөгөөд эдгээр нь хийц, хэлбэрийн хувьд өөр хоорондоо ялгаатай байдаг. Мөн эртний хүний оромж, дархны газар, ховор 14 хөшөө дурсгал, хадны бичээс, сүг зураг, ховор булш зэрэг огт судлагдаагүй эртний түүхийн дурсгал хаа сайгүй таруу байрлалтай тохиолдоно.

Мөн тус сум нь улсдаа Төрийн их тахилгат Алтан овоогоороо, шилийн сайн эр хийморь сүлдээ даатгаж сэргээдэг Шилийн богд уулаараа, дуу шүлгэнд мөнхөрсөн Ганга, Дуут, Холбоо нуураараа, 13 дугаар зууны үеийн түүхийг өгүүлэх 50 гаруй хүн чулуун хөргөөрөө, жил бүрийн намартаа чуулах мянга мянган хунгаараа, сийлж, ухаж, хөөж хийдэг дахин давтагдашгүй мөнгөн урлалын үе дамжсан Дарьганга хийцээрээ, Монголд байгаа 400 гаруй галт уулын 50 хувь нь оршдогоороо, тэгш тал дээр буй болсон Талын агуйгаараа, улс, бүс, аймгийн наадамд түрүүлдэг хурдан шандаст хүлэг морьдоороо алдартай.

Хүснэгт 26. Түүх соёлын дурсгалт газрын байршил

№	Дурсгалт газрын төрөл	Хөрөг	Байгалийн цогцолборт газар	Булш	Туурь	Дурсгалт газар
1	Үүд баг	1				
2	Бадрах баг	3	5	2		
3	Аман-Ус баг	2			2	
4	Овоот баг	1	3	3	2	2
нийт		7	8	5	4	2

Дарьганга суманд аялал жуулчлалын ач холбогдол бүхий аймгийн хэмжээний гол түүх, соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууд олон байдаг бөгөөд тэдгээрээс голлох үзвэрүүдийн заримаас товч тайлбарлавал.

Алтан-Овоо - Алтан овоо нь 1354 метр өндөр унтарсан галт уул бөгөөд уулын шовгор хэлбэр нь эвдрээгүй үлдсэн, хүрмэн чулуу ихтэй, амсар нь баруун хойшоо сэтэрч гарсан байдаг. Алтан-Овоог бүр 1700-аад оноос нутгийн тахилгатай, 1913 оноос төрийн их тахилгатай болгосон билээ. Нутгийн ард түмэн олон зууны турш шүтэж, тахиж ирсэн овоо бол Дарь Овоо юм. Дарь Овоо нь далайн түвшнээс дээш 1354 м өргөгдсөн бөгөөд Молцог элсний хойт захад, Дарьганга сумын төвийн баруун хойт захад оршдог. Аймгийн төвөөс 180 км зайтай, эртний сөнөсөн галт уулсын нэг юм. Галт уулын шовгор хэлбэр нь эвдрээгүй үлдсэн, галт уулын хүрмэн чулуу их, амсар нь баруун хойшоо сэтэрч урссан. Одоогоор Монгол улсын төрийн тахилгат уулсын нэг. Алтан-Овоог бүр 1700-аад оноос нутгийн зон олон тахиж ирсэн бөгөөд, 2004 онд Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар төрийн их тахилгат уул болгосон. Дарьгангын байгалийн цогцолборт газарт багтана. Дарь Овооны зүүн урд хормойд байдаг дөрвөн чулуун хөргийг 1998 онд улсын хамгаалалтад авсан.

Зураг 27. Алтан-Овоо

Ноён, Хатан, Хүү, Бэрийн чулуу - Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс зүүн тийш Ноён, хатан, хүү, бэр нэртэй дөрвөн хүн чулуун хөшөө бий. Энэхүү дөрвөн чулууг хоорондоо өөр төрлийн, өнгө зүс ялгаатай чулуугаар харилцан адилгүй ур чадвар гарган хийсэн боловч ерөнхий байдал, өмсгөн дүрсэлсэн хувцас эд хэрэглэлээр нь нэгэн цаг үед хамаарах соёлын дурсгал болохыг тогтоожээ. Ард түмний дунд Бэр хөшөө хэмээн нэрлэгдэн ирсэн хүн чулууг ШУА-ын Археологийн хүрээлэнгийн захирал Д.Цэвээндорж судлан эрэгтэй хүний баримал байна гэж тогтоожээ. Нутгийн ардууд ахуй амьдралдаа ойртуулах замаар домоглон Бэр хөшөө хэмээн нэрийддэг байсан байх хэмээн тайлбарлажээ. Түрэгийн үед хамаарах хувцас хэрэглэл бүхийгээр дүрслэгдсэн хүн чулуунууд буруу энгэртэй байдаг бол Монголын түүхэнд холбоотой хүн чулуунуудын дээл хувцасны энгэр нь зөв байдгаараа ялгарна.

Зураг 28. Ноён, Хатан, Хүү, Бэрийн чулуу

Ганга нуур, Оргихын булаг - Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс 12 километрт орших салхины нүүдлээс үүссэн хурмал элсэнд хаагдаж тогтсон нэгэн нуур байх бөгөөд түүнийг Ганга нуур гэдэг. Ганга нуур нь 4 ам километр талбайтай нуур бөгөөд Ганга гэдэг нь үүрд ширгэшгүй ундран оргилдог мөнх гэсэн утгатай үг ажээ. Ганга нууранд Монголын улаан номд ордог гангар хун, цэн тогоруу гэх мэт нэн ховор шувууд ирж зусдаг. Жил бүрийн намар хун шувууд олон зуугаараа нисэн ирж ганганан чуулдаг учраас Ганга нуурын 1000 хунгийн чуулган гэж алдаршсан юм. Ганга нуурыг усыг 21 булаг тэтгэн тэжээдэг бөгөөд тэдний гол амин судас нь Дагшин оргихын булаг билээ.

Нуурын зүүн хойно 50 метр зайд газрын гүнээс тунгалаг устай хүйтэн булаг оргилон гардгийг Оргихын булаг гэж нэрлэдэг. Нарийн ширхэгтэй элсний доороос даргилан буцалж байгаа юм шиг оргилон гарах бөгөөд чангаар дуугарах тусам улам ихээр элс бужигнан оргилдог онцлогтой билээ.

Бичигтийн шахаа - Энэ газар нь одоогийн Дарьганга сумын төвөөс зүүн хойш 40-өөд км-т байдаг. Зүүн талаасаа огт мэдэгдэхгүй цэлийсэн тал үргэлжилж байгаад гэнэт доош цөмрөх мэт эгц буусан 40-өөд м-ийн өндөртэй, 90 градиусын эгц, 1 км хэртэй урт хадан хясаа юм. Буу зэвсэг ховор байсан үед хүмүүс энэ гайхамшигт хясааг ан гөрөөний ажилд ашиглан зээр гөрөөсийг үй олноор нь сууриар нь шахаж оруулан агнадаг байжээ. Ийм учраас "Шахаа" нэрийг олсон байна гэсэн домогтой. Энэ "шахаа"-г "Бичигтийн" гэж нэрлэсэн тухайд: уул хадан хясааны эгц энгэрүүдээр их хэмжээний бичгүүд байснаас болсон гэх бөгөөд тэр бичгүүдийг "Амьтныг ингэж үүрээр нь сүйтгэж болохгүй" гэсэн харууслын бичээс байсан гэсэн домог үлджээ.

Талын агуй - Талын агуй нь Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт Шилийн богд уулаас хойш 15 км зайд, тэгш талд оршино. Агуйгаас зүүн урагш 2 км-д унтарсан галт уул бий. Талын агуй х.ө.45°35'25,00", з.у.114°30'02,06" газарзүйн солибцолд оршино. Агуйн ам далайн түвшнээс дээш 1250 м өндөрт, 4.5 м гүн 484м3 ус цуглуулах талбай бүхий хонхорын зүүн талын ёроолд оршино. Энэ агуй тэгш талд байрлах тул олж очиход нилээд түвэгтэй боловч агуйн дэргэд

чулуун овоо босгосон тул тал газар нилээд содон байдаг.

Шилийн богд - Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас зүүн урагш 60 км-т д.т.дээш 1778 метрт оршдог Дарьгангын энэ өндөрлөг тэгш газарт 200 орчим унтарсан галт уул байдгийн хамгийн өндөр нь Шилийн богд уул юм. Богд уул гэх нэршил нь сүүлд Буддын шашны нөлөөгөөр нэмэгдэж нэрлэгдсэн нэршил бөгөөд эрт дээр үеэс Монголчууд "Шивээт шил" "Агшуун" хэмээн нэрийддэг байсан ба тал нутгийн их хайрхан хэмээн тахин шүтэж иржээ.

Торой бандийн хөшөө - Халхын шилийн сайн эрсийн нэг "Төрийн бөөс" хэмээн алдаршсан Тоорой банди буюу Нанзад 1834 оны үед Бударын чулуу гэдэг газар төржээ. Чойном гуайн уянгалсан алдарт сүмтэй Бударын чулуу. Нанзад цахар хүн бөгөөд 1860-аад онд цахар найман хошуу төдийгүй халх даяар нэр нь түгсэн шилийн сайн эр байлаа.Тоорой бандийн тухай бичиж үлдээсэн зүйл үгүй бөгөөд олны ам дамжсан домог хууч элбэг. Багаасаа ээжтэйгээ ядуу тарчиг өссөн ба эрийн цээнд хүрээд эр чадлаараа баяд ноёд, харийн худалдаачдын эсрэг тэмцэн олсон олзоо дан ганц амин хувьдаа бус нутгийн олонтойгоо хуваадаг байсан нь олон түмний хүндлэл хайрыг хүртжээ. Мөн тэр дуулж хуурддаг авъяаслаг нэгэн байжээ. Насан өндөр болоод Нанзад гуай Бударын чулуу ,Таван толгой , Шартын хад хавиар нутаглаж байгаад 1904 онд нас баржээ.

Асгат сум

Асгат сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Дарьганга уулын хошууны нутгаас салган Дорнод аймгийн харьяанд байгуулжээ. 1942 онд Сүхбаатар аймгийг байгуулахад харьяанд нь шилжүүлсэн байна. Сумын төв Улаандэл суурин нь аймгийн төвөөс зүүн урагш 48 км зайтай. Алаг Морьтын хүн чулуун хөшөө, Авдарын голын хийдийн туурь Авдарын голын хөндийн булш, Бөөрийн хийдийн туурь, Хар Овооны хөндийн булш, Тахилын онгон, Цагаан суваргын дурсгал, Шаргын уулын булш зэрэг түүх соёлын үл хөдлөх дурсгалуудтай.

Асгат сумын нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалууд:

Асгат сумыг УБХ-ын Тэргүүлэгчдийн 1931 оны 5 дугаар хурлын тогтоолоор хуучны Хан Хэнтий уулын аймгийн Дарьганга уулын хошууны нутгаас салган Дорнод аймгийн харьяанд байгуулжээ. 1942 онд Сүхбаатар аймгийг байгуулахад харьяанд нь шилжүүлсэн байна. Сумын төв Улаандэл суурин нь аймгийн төвөөс зүүн урагш 48 км зайтай. Алаг Морьтын хүн чулуун хөшөө, Авдарын голын хийдийн туурь, Авдарын голын хөндийн булш, Бөөрийн хийдийн туурь, Хар Овооны хөндийн булш, Тахилын онгон, Цагаан суваргын дурсгал, Шаргын уулын булш зэрэг түүх соёлын үл хөдлөх дурсгалуудтай. (Соёлын өвийн төв, "Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгал" 2-р дэвтэр, 2008 он)

1. Алаг Морьтын хүн чулуун хөшөө

Асгат сумын төвөөс баруун урд зүгт 25 орчим км-т, Алаг Морьт гэх газар хэсэгхэн чулуун овоолгын дунд нэгэн хүн чулуун хөшөө бий.

2. Авдарын голын хийдийн туйр

Сумын төвөөс урагш 7 орчим км-т, Авдарын голын хойд энгэрт Авдарын хийдийн туурь оршино. нутгийн иргэд ойрын үед тус хийдийн туурь дээр суврага бүтээн залжээ.

3. Авдарын голын хөндийн булш, зэл чулуу

Сумын төвөөс урагш 7-12 орчим км, Авдарын голын хөндийд дөрвөлжин, дугуй нийлсэн 30 гаруй булш, зэл чулууд бий.

4. Бөөрийн хийдийн туурь

Сумын төвөөс баруун урд зүгт 50 гаруй км-т, Их Уулын хойд хөндийд Бөөрийн хийдийн туурь оршино. Хийдийн туурь дээр ойрын үед нутгийн иргэд суврага бүтээн залжээ

5. Хар овооны хөндийн булш, тахилын онгон

Сумын төвөөс зүүн зүгт 40-өөд км, Хар Овооны гэх хөндийд дөрвөлжин дугуй булш болон Түрэгийн үеийн тахилын онгон цөөнгүй бий.

6. Цагаан суваргын дурсгал

Сумын төвөөс зүүн тийш 35 орчим км, Өлзийт багийн төвөөс зүүн тийш 20 гаруй км-т, цагаан суварга хэмээх орой дээрээ том цагаан хадтай намхан уул бий. Энэ уулын энгэрт орших задгай худгийн зүүн хойд талд 1 хүн чулуун хөшөө, 1 цулгуй хөшөө болон хэдэн босоо чулуутай зэл чулуу бий.

БҮЛЭГ 13. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ

13.1. Хүн амын тоо ба өрхийн байдал

Асгат сум:

Хүн ам

УИХ-ын 2004 оны 4-р сарын 23-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор "Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого"-ыг баталсан. Уг бодлогод хүн амын өсөлтийн талаар "Хүний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн чөлөөт сонголт бүхий зохистой төрөлтийг дэмжиж, өвчлөл, нас баралтыг бууруулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана." гэж заасан байдаг. Хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх үүднээс төрөлт, гэр бүлийг дэмжих бодлого баримталж байна. (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022 он)

Хүн амын тоо

2017 оны дүнгээр тус сумын хүн амын тоо 1808 үүний эрэгтэй 932, эмэгтэй 876 байсан бөгөөд 2022 онд хүн амын тоо 1952 болж үүнээс эрэгтэй 992, эмэгтэй 960 болж нийт хүн ам 9.8 хувиар өссөн байна.

№	Багаар	2017	2018	2019	2020	2021	2022
1	Асгат сум	1808	1880	1878	1948	1981	1952
2	1-р баг Өлзийт	349	365	384	392	390	371
3	2-р баг Дөхөм баг	438	464	464	481	502	495
4	3-р баг Их-Уул	445	467	462	465	460	444
5	4-р баг Жаргалант	576	584	568	610	634	642

Боловсрол

Ерөнхий боловсролын сургууль: Асгат сумын бага сургууль нь анх 1938 онд "Хөтөлийн хошуу" гэдэг газар 1 багш 10 сурагч 2 гэртэйгээр байгуулагдаж байсан.1940 онд Улсын бага сургууль 1973-1974 оны хичээлийн жилээс эхлэн бага сургуулийн материаллаг бааз дээр түшиглэн 8 жилийн сургууль болон өргөжиж. 2008 онд Монгол улсын түүхийн ухааны доктор Гүнжийн Сүхбаатарын нэрэмжит , 2015 оноос 9-н жилийн сургалттай ЕБС болсон.

Тус сургууль нь эдүгээ 12 бүлэг 295 суралцагч захирал, сургалтын менежер, нярав, ня-бо дотуур байрын багш, номын санч-бичиг хэрэг, бага боловсролын 7 багш, мэргэжлийн 9 багш, сантехникч, жижүүр тогооч, галч, үйлчлэгч гэсэн 39 ажилтан албан хаагчтайгаар хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Багш нараас Тэргүүлэх зэрэгтэй 1, Заах аргач зэрэг 6 багштай бөгөөд мэргэжлийн багшаар 100% хангагдсан. Манай хамт олны дунд эрхэлсэн ажилдаа амжилт бүтээл гарган ажиллаж төр засгийн одон медаль болон аймаг, сум байгууллагын шагналаар шагнагдсан боловсон хүчнүүд ажиллаж байна. 2021 оны байдлаар Асгат сумын ерөнхий боловсролын 9 жилийн дунд сургуульд нийт 12 бүлэг, 40 хүүхэд шинээр хамрагдаж, нийт 295 хүүхэд суралцаж байгаагаас эмэгтэй хүүхэд 138 буюу 46.78% байна. Үндсэн багшийн тоо 16, ажилчид 39, секц дугуйлан 8, 1 спорт заалтай.

Эрүүл мэнд

Асгат сумын Эрүүл мэндийн төв нь 1938 онд Бөөрийн төв гэдэг газар сувилагчийн салбар нэртэйгээр байгуулагдаж сувилагч-1 санитар-1 гэсэн орон тоотой ажиллаж эмнэлгийн анхны тулгын чулуу тавигдсан. Анхны сувилагчаар С.Батсүх ажиллаж байсан. 1942 оноос бага эмчийн салбар болж анхны бага эмчээр Д.Ядамсүрэн ажиллаж байв. 1975

оноос их эмчийн салбар болон өргөжиж Их эмчээр Ш.Оюунцэцэг томилогдон ажиллаж байсан. 1982-1984 он хүртэл их эмчээр Х.Цэгмаа ажиллаж байгаад 1984 оноос 2017 он хүртэл Л.Нанзад салбарын эрхлэгч их эмчээр ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарч салбарын эрхлэгч их эмчээр Б.Сумъяасүрэн ажиллаж байна.

2015 онд Асгат сумын үүсгэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойгоороо Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан Гунгаагийн Содномдаржаагийн нэрэмжит эмнэлэг болсон.

Тус эмнэлэг нь одоогийн байдлаар 4 багийн 1947 хүнд 8 ортой, 24 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа ба их эмч-3, Эх баригч бага эмч-1, Дүн бүртгэгч бага эмч-1 Багийн бага эмч-3, Ахлах сувилагч-1, ээлжийн сувилагч -4, лаборант-1, нягтлан бодогч-1, бичиг хэргийн ажилтан-1, туслах сувилагч-2, үйлчлэгч-1, жолооч-1, тогооч-1, галч-3 гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Соёл урлаг

Асгат сумын соёлын төв нь 1936 онд Бөөрийн төв-д " Улаан гэр" нэртэйгээр байгуулагдсан бөгөөд " Улаан гэр"-ийг Б. Загдсүрэн гэдэг хүн хариуцан ажиллаж байсан байна.

1959 онд Асгат сум Улаан дэлд нүүж ирэн 1969 онд орон нутгийн иргэдийн хүчээр клуб, номын сангийн барилгыг аж ахуйн аргаар барьж ашиглалтад оруулж 2009 он хүртэл ашиглаж байсан.

1960 онд номын сан нь 200 номтой , 12 уншигчийн суудалтай байгуулагдаж анхны номын санчаар Ш. Алтанцэцэг ажиллаж байжээ. Сумын нийтийн номын сан нь иргэд хөдөлмөрчдөд тасралтгүй үйл ажиллагаа явуулан ажиллаж байгаа бөгөөд сумын нийт хүн ам болон сургуулийн сурагчдад үйлчилдэг байсан ба сургууль 2005 оноос бие даасан номын сантай олж сум сургуулийн 2 номын сан үйл ажиллагаа явуулан ажиллаж байна.

Дэд бүтэц, Харилцаа, холбоо

Асгат сумын нутаг дэвсгэрт Мобиком, Скайтел, Юнител, Ж-мобайл, МЦХ зэрэг операторууд сүлжээ нэвтэрсэн байна. Малчдын дийлэнх нь Жи-мобайлын сүлжээ ашиглаж харилцаж байна.

Малчин өрхүүд сансрын антенаар дамжуулан үндэсний радио, телевизийн нэвтрүүлгийг хүлээн авч үздэг.

Эрчим хүч

Асгат сум цахилгаан дамжуулах агаарын шугамаар төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. 35 квт-ын дэд станцтай.

Аж үйлдвэр

Асгат суманд нийт 2023 оны 1-р улирлын байдлаар 21 ААНБ байгаагаас 9 компани, 2 нь хоршоо, 1 нөхөрлөл, 6 төсвийн байгууллага, төрийн бус байгууллага 3 байна. Тус сумын хэмжээнд 2019 онд 21 ААНБ бизнесийн регистрийн санд бүртгэгдсэн байгаа ба бусад онтой харьцуулахад хамгийн олон ААНБ бүртгэгдсэн байна. (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022 он)

Хөдөлмөр эрхлэлт

Асгат сумын хэмжээнд хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2021 оны байдлаар 8 байгаа ба 2017 онтой харьцуулахад 82.0%-иар буурсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2017 онд 192 байсан бол 2021 онд 95 болж 66.5%-иар буурсан үзүүлэлттэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдээс 2021 онд 52 хүн ажилд орсон байна. (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2023 он)

Дарьганга сум:

Хүн амь зүй

УИХ-ын 2004 оны 4-р сарын 23-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор "Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого"-ыг баталсан. Уг бодлогод хүн амын өсөлтийн талаар "Хүний нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэсэн чөлөөт сонголт бүхий зохистой төрөлтийг дэмжиж, өвчлөл, нас баралтыг бууруулах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана." гэж заасан байдаг. Хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх үүднээс төрөлт, гэр бүлийг дэмжих бодлого баримталж байна. (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан , 2022 он)

Хүн амын тоо

2017 оны дүнгээр тус сумын хүн амын тоо 3056 үүний эрэгтэй 1528, эмэгтэй 1528 байсан бөгөөд 2019 онд хүн амын тоо 3079 үүний эрэгтэй 1540, эмэгтэй 1539 тоологдсон ба 2022 онд хүн амын тоо 3242 болж үүнээс эрэгтэй 1621, эмэгтэй 1621 тоологдсон байна.

№	Багаар	2017	2018	2019	2020	2021	2022
1	1-р баг, Үүд	629	640	647	659	654	660
2	2-р баг, бадрах	758	767	763	788	818	853
3	3-р баг, Аман-Ус	534	543	556	537	554	563
4	4-р баг, Овоот	1135	1133	1113	1153	1168	1166
	Нийт	3056	3083	3079	3137	3194	3242

Малчин өрх

Малчин өрхөд жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, малаас ашиг шим олж байгаа нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хамруулна. Малтай өрх гэж мал бүхий өрх болон малчин өрхийг хэлнэ. Мал бүхий өрх гэж малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг ойлгоно. Дарьганга сумын хэмжээнд 2022 оны байдлаар 560 өрхийн буюу нийт өрхийн 58.4% нь малчин өрх байна. (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022 он)

Эрдэнэ мэнд

Дарьганга сумын хүн эмнэлэг нь 1948 онд Баянголд 5-н ортойгоор байгуулагдан хүний бага эмч асрагчаар Гэндэн, Дугарсүрэн нар ажиллаж байжээ. 1970-аад оноос сумын төвд эх нялхсын амаржих байр нээгдэж хөдөөгийн малчин эхчүүд энэ төвд ирж төрдөг байсан. 2000-2010 оны хугацаанд их эмч Г.Тунгалаг, их эмч Ж.Нарандэлгэр нар ирж ажиллаж байсан. 2001 онд Монгол Германы хамтарсан GTZ төслөөр НҮЭМ-ийн цогцолбор үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.2006, 2008 онуудад 5 сая төгрөгийн эмнэлгийн ор тоног төхөөрөмж авч, ЭМЯ-ны буцалтгүй тусламжаар түргэний авто машинтай болсон. (Сүхбаатар аймгийн Дарьганга сумын албан ёсны сайт, 2022 он)

Эмнэлгийн шинэ барилга нь 2019 онд Эрдэнэ мэндийн яамны захиалгаар, улсын төсвийн 915.6 сая төгрөгийн санхүүжилтээр баригджээ.

Соёл урлаг

Дарьганга сумын соёлын төв нь 1957 онд байгуулагдсан. 2012 онд шинэ байранд орсноор урлаг, уран сайхны үйлчилгээг сум орон нутгийнхаа иргэдэд цаг тутам хүргэх боломж бүрджээ. Өдгөө зургаан хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг бөгөөд дэргэдээ орон нутаг судлах танхимтай. Соёлын төвийн эрхлэгч Д.Үржинлхам.

2017 онд Соёлын төвийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор тус сумын уугуул, Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Зундуйн Батсүхийн нэрэмжит болголоо. (Сүхбаатар аймгийн Дарьганга сумын албан ёсны сайт, 2022 он)

Дэд бүтэц

Харилцаа, холбоо

Дарьганга сумын нутаг дэвсгэрт Мобиком, Скайтел, Юнител, Ж-мобайл, МЦХ зэрэг операторууд сүлжээ нэвтэрсэн байна. Малчдын дийлэнх нь Жи-мобайлын сүлжээ ашиглаж харилцаж байна.

Малчин өрхүүд сансрын антенаар дамжуулан үндэсний радио, телевизийн нэвтрүүлгийг хүлээн авч үздэг.

Эрчим хүч

Сум нь эрчим хүчний төвлөрсөн системд 10кВ-ын шугамаар холбогдсон. 2 дэд станцтай. Сумын төвд 1 төвлөрсөн уурын зуух ажиллаж 1,36 км шугамаар хэрэглэгчдийг хангаж байна.

Аж үйлдвэр

Дарьганга суманд нийт 2022 оны байдлаар 38 ААНБ байгаагаас 2- нь компани, 3 нь хоршоо, 2 нөхөрлөл, 1 төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар, 7 төсвийн байгууллага, 3 төрийн бус байгууллага байна. (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022 он)

Хөдөлмөр эрхлэлт

Дарьганга сумын хэмжээнд хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2021 оны байдлаар 34 байгаа ба 2017 онтой харьцуулахад буурсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2017 онд 63 байсан бол 2021 онд 177 болж өссөн үзүүлэлттэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдээс 2021 онд 30 хүн ажилд орсон байна. (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022 он)

БҮЛЭГ 14. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛҮҮД

14.1. Үүсэж болзошгүй нөлөөлөл, аюулууд

Төслийг хэрэгжүүлэх үед байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимжил зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг. Энэ арга нь тухайн байгууллагын үйл ажиллагааны ашиглалтын үед нөлөөлөл мар байгаа эсэх дээр тулгуурладаг бөгөөд хэрэв тухайн нөлөөлөл "х" болон "+" тэмдэглэдэг.

Хүснэгт 27. Нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөх байдал			Хугацаа		Эргэлт		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага	Дунд	Хүчтэй
Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Гадаргын усны урсцын өөрчлөлт		х		х		х		Х		
Гадаргын усны чанарын өөрчлөлт		х		х		х		х		
Ой, ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х		Х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	Х				Х		х		х	
Геологийн тогтцын өөрчлөлт		х		х			Х	х		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		х			х		х	Х		
Уур амьсгалын /бичил/ өөрчлөлт		х			х	х		х		
Байгалийн нөөц ашиглалт										
Бэлчээр, тэжээлийн байдал	х				х		х	х		
Эрдэс түүхий эдийн нөөц /ус/	х				х		х	х		
Эрчим хүчний нөөц	х				х		х	х		
Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	х				х	х		х		
Урсгал усны нөөцийн горим		х		х			х	х		
Агаарын бохирдол	х				х	х			х	
Хөрсний, бохирдол элэгдэл	Х				х	х			х	
Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх	х				х	х				х
Дуу чимээний нөлөөлөл	х				х		х		х	
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+		+	
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	+				+		+		+	

Хүн амын орлого өөрчлөгдөх	+				+		+		+	
Хүн амын эрүүл мэнд, соёл	+				+		+		+	
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл , археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	+				+		+			+
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	+				+		+			+
Эдийн засаг, нийгмийн асуудал										
Татварын орлого өөрчлөгдөх	+				+		+		+	
Орон нутгийн орлог өөрчлөгдөх	+				+		+		+	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+		+		+	
Ажлын байр нэмэгдэх	+				+		+		+	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+		+		
Бусад нөлөөлөл										
Ахуйн бохир уснаас хөрс, газрын доорх ус бохирдох	x			x		x		x		
Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, элдэв төрлийн нян, хорхой шавж үржих	x			x		x			x	
Дүн	**24**	**6**	**-**	**7**	**22**	**9**	**19**	**12**	**14**	**3**

Тайлбар: ”x” сөрөг нөлөөлөл, “+” эерэг нөлөөлөл

Хүснэгтээс үзвэл байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх болзошгүй нөлөөллийн нийт тоо 29 байна.

Нөлөөллийн байдал:

Шууд нөлөөлөл:

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд, буцалтгүй, дунд зэргийн эрчимтэй нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

Шууд бус нөлөөлөл:

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;
- Орон нутгийн иргэдээс ажилчид авах зэргээр урт хугацаанд эерэг нөлөөлнө;

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

14.2. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт, хэрэгжилттэй холбогдсон болзошгүй нөлөөлөл

“Кеаро” ХХКомпанийн “Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам” зураг төслийн байршил, техник технологийн шийдэл, төлөвлөлт болон төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой болзошгүй нөлөөллийг тодруулахын тулд "магадлан жагсаах" аргыг хэрэглэн үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 28. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
			Бага	Дунд	Их
1. Төслийн байршилтай холбогдон гарах нөлөөлөл					
1	Хүн ам нүүлгэн шилжүүлэх асуудал	0			
2	Тусгай хамгаалалттай бүс нутгийн ховор, ховордсон биологийн төрөл зүйлийн амьдрах орчин	0			
3	Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүргэх	0			
4	Ой модыг огтлох, гэмтээх асуудал	0			
5	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	0			
6	Булаг шандын усны горимд өөрчлөлт орох ба хатаж ширгэх аюултай эсэх	0			
7	Голын голдирол эвдэж өөрчлөх эсэх	0			
8	Байгалийн эрдэс баялгийг ашиглах эсэх	0			
2. Төслийн шийдэлтэй холбогдол бүхий нөлөөлөл					
9	Үйл ажиллагаа нь тухайн орон нутагт нийцтэй эсэх	+	+		
10	Төслийн үйл ажиллагаанд тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, бодис хэрэглэх эсэх	0			
11	Төслийн үйл ажиллагаанд сонгосон техник, тоног төхөөрөмжийн шийдэл, түүхий эд нь байгаль орчинд хэр нийцтэй эсэх	+		+	
3. Төслийн барилга байгууламж барих үеийн нөлөөлөл					
12	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед усны нөөц бохирдох эсэх	-	-		
13	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед хөрсний эвдрэл, элэгдэл, бохирдол	-		-	
14	Үйлдвэрийн үйл ажиллагааны аюул ослын нөхцөл үүсэх эсэх	-	-		
4. Төслийн үйл ажиллагааны холбогдол бүхий нөлөөлөл					
15	Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх	+		+	
16	Хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах орчныг тохижуулах төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан эсэх	+			+
17	Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс, ургамал талхлагдах эсэх	-		-	
18	Төслийн байгууламж хоорондын хөрсний бохирдлыг багасгах талаар төлөвлөгөөнд тусгагдах эсэх	+	+		
19	Төслийг хэрэгжүүлэхэд орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөлөх	-	-		
20	Ядуурлыг бууруулах	+	+		
21	Эдийн засгийн өсөлт	+	+		
22	Онцгой нөлөөлөл	0			

Тайлбар: (0) нөлөөлөлгүй
(-) сөрөг нөлөөлөлтэй
(+) эерэг нөлөөлөлтэй

-	5	23.8 %
+	7	31.8%
0	10	45.4%

Дээрх нөлөөллийн үнэлгээнээс тооцож үзвэл энэ төсөл байгаль орчинд нөлөөлөх байдлаараа "бага" нөлөөлөлтэй бөгөөд нөлөөллийн эрчим бага байна. Хөрсний эвдрэл, бохирдол, Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх, Газрын доорх усны чанарын өөрчлөлт, Зэрлэг амьтдын дайжих зэрэг 4 зүйлийн дунд нөлөөлөл, түүх соёлын өв, соёлыг түгээх, орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, орон нутгийн хөгжил зэрэгт бага эрчмийн эерэг нөлөөлөлтэй байна.

14.3. Байгаль орчин, нийгэмд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

Хүснэгт 29. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийг ангилах нь

№	Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл	
1	Агаарын чанар, дуу шуугиан	▪ Шуугиан ▪ Тоос ▪ Хорт хий ▪ Доргио, чичиргээ гэх мэт
2	Газрын гадарга, хөрс	▪ Газар ашиглалт ▪ Хөрсний элэгдэл, эвдрэл ▪ Хөрсний бохирдол гэх мэт
3	Ургамал, амьтан	▪ Ургамлын төрөл зүйл ▪ Амьтдын төрөл зүйл ▪ Ургамлын бүрхэц ▪ Амьтны аймгийн тархалт гэх мэт
4	Гадаргын болон газрын доорх ус	▪ Гадаргын болон газрын доорх усны хэрэглээ ▪ Усны чанар гэх мэт
5	Бусад	▪ Түүх соёлын дурсгал ▪ Нийгэм эдийг засаг гэх мэт

14.3.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- "Кеаро" ХХКомпанийн "Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам" зураг төслийн үйлчилгээнд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийн орчны агаарт бий болгож байгаа бохирдлыг багасгах үүднээс тэдгээрт засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал утааны шүүлтүүр ашиглах, утаанд хяналтын хэмжилтийг сар тутам хийлгэж байхаас гадна, ашиглалтын хугацаа дуусан тээврийн хэрэгслийг ашиглалтаас гаргах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх
- Төсөл хэрэгжих орчмын агаарт жилд 2-оос доошгүй удаа буюу 1, 8-р саруудад орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшнийг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах
- Ахуйн хог хаягдлыг ариун цэврийн бүсийн гадна, түүнээс 60м-ээс багагүй зайд, салхины зонхилох чиглэлийн дагуу, "Кеаро" ХХКомпанийн "Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам" зураг төслийн барилга байгууламжийн доод талд ус үл нэвтрэх дотортой, зориулалтын саванд цуглуулна. Энд муудаж болзошгүй, чийгтэй юм уу, муудсан зүйл хаяж болохгүй. Энд халдваргүйжүүлэх, нян устгах ариутгалыг мэргэжлийн байгууллагаар тогтоосон хугацаанд хийлгэж байвал зохино.

- "Кеаро" ХХКомпанийн "Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам" зураг төслийн барилга байгууламжийн зураг төсөлд тусгагдсан явган зам, тоглоомын талбай, тээврийн хэрэгслийн зогсоол зэрэг газруудыг технологийн дагуу хучилт хийж байгуулна. - Халаах, хөргөх хэрэгслүүдэд ашиглах пропан, ферон зэрэг хийг бөөнөөр нь авч технологийн бус нөхцөлд хадгалах, хөргөх төхөөрөмжийг мэргэжлийн бус хүнээр цэнэглүүлэхийг хориглоно.
- Төсөлд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох
- Төв замаас төсөл хэрэгжих талбай хүртэл автозамыг сайжруулсан буюу хатуу хучилттай болгох

14.3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно. /Усны тухай хуулийн 22.1.-д/ Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно. /Усны тухай хуулийн 22.2.-д/ Онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно. /Усны тухай хуулийн 22.2.1.-д/

Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно. /Усны тухай хуулийн 22.3.-д/

Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд энэ журмаар онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, бүсэд мөрдөх дэглэмийг тогтооно. /Усны тухай хуулийн 22.4.-д/

Урсац сайтай булгууд болон горхины ус хамгаалах, хориглох бүсийг тэдгээрийн урсцын уртаас хамааруулан тогтооно. Гол мөрөн нуурын дүрс зүйн элемент горхи, булаг шандын ундарга болон урсцын уртаас хамааруулан ус хамгаалах бүс ба аж ахуй үйл ажиллагааг хориглох бүсийг тогтооно.

Хүснэгт 30. Хамгаалах бүс

Гол горхины урт (км)	Хамгаалах бүсийн өргөн, голын захаас (м)	Хориглох бүс, голын захаас (м)
<24	50	25
24-49	100	50
50-100	200	100
>101	300	150

Булаг, горхины эхэнд үйл ажиллагаа явуулан хүн малын хөл тасрахгүйгээс шалтгаалан түүний ойр орчмын хөрс дагтаршиж, талхлагддаг. Иймд булаг, горхины усны эх ундаргаас хамааруулан хориглолтын бүсийн хил хязгаарын дагуу зориулалтын хашаа барьж хамгаалах зайлшгүй шаардлагатай.

- Үйл ажиллагааны явцад ажилтан, үйлчлүүлэгчдийн унд-ахуйн хэрэгцээний усны эрүүл ахуй-ариун цэврийн шаардлагыг хангах арга авч хэмжээг хэрэгжүүлэх
- Ахуйн хуурай хог хаягдлын цэг болон шингэн хаягдлыг зайлуулах шугам сүлжээ, машин техникийн зогсоол зэргийг жалга, суваг шуудуунаас хол зайд байрлуулах
- "Кеаро" ХХКомпанийн "Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам" зураг төслийн талбай, болон эргэн тойрны газарт хатуу хог хаягдал хуримтлагдахгүй байх талаар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хуримтлагдсан хог хаягдлыг тухай бүр цэвэрлэж байх
- Унд ахуйн усны хэрэгцээнд хяналт тавих, тооллууржуулах, усны хэрэглээг багасгах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх
- Шингэн хаягдлыг бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулан цэвэрлэж, зүлэг ногоо мод услах, тоосжилт дарах зэрэгт эргүүлэн ашиглах
- Ойр орчмын гол горхид хог хагдал хаяхгүй, зүй зохистой үйл ажиллагаа явуулах, байгаль орчноо хамгаалах талаар сургалт, анхааруулгыг ажилчид болон, амрагчдад таниулан сурталчлах
- Аливаа аж ахуйн үйл ажиллагаа явуулахдаа сайраар хур борооны болон хайлсан цас мөс ус чөлөөтэй урсан өнгөрч урсгалын доод хэсэг дэх бэлчээр, хөрсний чийгт эергээр нөлөөлөх байдал, хотгор хонхор дүүргэх, газар доорх усыг сэлбэх нөхцөлийг хангах
- Ундны усны эх үүсвэрийг тодорхойлон MNS 0900 : 2010 "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" стандартын шаардлагыг хангасан ундны усыг ашиглах
- Ундны ус хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж, эдгээр үйл ажиллагаанд тохируулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.
- Ахуйн хэрэглээнд ашиглахаар хурын ус цуглуулах, нөөцлөх бичил байгууламжтай байна.

14.3.3 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Төсөл хэрэгжих талбайн тарималжуулалтын болон цэцэрлэгжүүлэлтийн талбайн ургамлан бүрхэвчийн нягтралыг даруй нэмэгдүүлэх, тус үнэлгээний тайлангийн ногоон байгууламж байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэх
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, ашиглах газрын хэмжээг зөрчих, өөр зориулалтаар үйл ажиллагаа явуулах, барилга барихыг хориглоно.
- Хөрсийг аль болох сэндчилж ухахаас сэргийлэх
- Хүчтэй эвдэрсэн газрын хөрсийг сэргээхэд олон настын үрийг хавар бороо орохоос өмнө угтуулж, хөрсөнд цацаж, хүн, малын нөлөөллөөс хамгаалах
- Машины хатуу хучилттай зогсоол байгуулж, тэмдэгжүүлэх
- Гал түймрийн аюулаас ямагт сэрэмжилж, урьдчилсан арга хэмжээ төлөвлөн галын хор, элсний нөөцийг нэмэгдүүлэх.
- Үйлчлүүлэгчдэд байгаль орчноо хамгаалах талаар сурталчилгаа сургалтын ажлыг өргөнөөр зохион байгуулж явуулах
- Эргэн тойрны 0.5-1.0 км радиустай газрыг хяналтдаа авч бохирдохоос сэргийлж, тогтмол цэвэрлэж байх

БҮЛЭГ 15. АШИГЛАСАН МАТЕРИАЛ ЭХ СУРВАЛЖ

1. "Кеаро" ХХКомпанийн ""Сүхбаатар аймгийн Дарьганга сумаас Бичигт боомтын төв зам хүртэлх хатуу хучилттай авто зам" зураг төслийн танилцуулга
2. Жамбаажамц "Монгол орны уур амьсгал", Улаанбаатар хот.1989 он
3. Цаг уур орчны шинжилгээний газрын Архив мэдээллийн сангийн хэлтэс
4. Монгол улсын үндэсний атлас. ШУА-ийн газарзүйн хүрээлэн. 2009 он
5. Жигж.С "Монгол орны хотгор гүдгэрийн үндсэн хэв шинж", Улаанбаатар хот.1979 он
6. Даваа.Г, Сугар. Ц, 1999, Монгол орны гадаргын ус. Улаанбаатар хот.
7. Туул голын усны чанарын 2018 оны 8 дугаар сарын төлөв байдал
8. 1933-2008 оны хооронд хийж байсан гидрогеологи, инженер-геологийн судалгааны тайлангуудыг иш үндэс болгов.
9. Төмөрбаатар.Д, 2004, ШУА, ГЗХ, Цэвдэг судлалын лаборатори, Монгол орны улирлын болон олон жилийн цэвдэг чулуулаг, Улаанбаатар хот.
10. Даваадорж.Д, "Бэлчээрийн хөрсний физик шинж чанар ба ургамлан нөмрөг, тэдгээрийн өөрчлөлт", Улаанбаатар хот.2006 он
11. "ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ" ХХК, Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторийн хариу
12. Жигжидсүрэн.С, "Монгол орны бэлчээрийн ургамлууд",Улаанбаатар хот.2006 он
13. Өлзийхутаг.Н "БНМАУ-ын бэлчээр хадлан дахь тэжээлийн ургамал таних бичиг", Улаанбаатар хот.1985 он
14. Ж.Өлзийсайхан ба Н.Болдбаатар "Экологи байгаль хамгаалал" лекцийн эмхэтгэл, УБ 2006.
15. Батсайхан Н., Сумъяа Р., Шар.Р, King C.R.B, 2010, Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага, Улаанбаатар хот.
16. http://srtm.csi.cgiar.org/SELECTION/inputCoord.asp
17. http://glovis.usgs.gov
18. http://earthexplorer.usgs.gov
19. www.legalinfo.mn
20. www.estandard.mn
21. www.eic.mn
22. www.wikipedia.mn
23. www.loadmap.net
24. www.1212.mn